

# НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН

## 2019 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

### 9.1.1 НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”

Эмнэлгийн Түргэн тусламж үйлчилгээний журмыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон ЭМЯ-ны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн А/294 тоот ” Түргэн тусламжийн үйлчилгээг зохион байгуулах үлгэрчилсэн журам” батлагдан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн гарган мөрдөж байна. Ингэснээр дуудлагын ангилал тогтвортой болж, хүлээгдэл буурч салбар хоорондын уялдаа холбоо сайжирсан.

Стандартчилал хэмжил зүйн Үндэсний төвийн 2018 оны 05 сарын 31-ны 09 тогтоолоор Түргэн тусламжийн үйл ажиллагааны стандарт MNS6717:2018 стандартыг мөрдлөг болгон шаардлагатай орон тоо, эмнэлгийн хэрэгсэл, автомашиныг зохих шатны байгууллагад хандан ажиллаж байгаа болно.

#### а/ “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”

Зорилт 2: Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

1. 2019 оны жилийн байдлаар тус төвийн үйл ажиллагаатай холбоотой эхийн эндэгдэл гараагүй. Эмнэлгийн бус, гэрийн төрөлт 83 тохиолдол гарсан ба 2018 оны мөн үеэс 46 тохиолдлоор буурсан. Гэрийн төрөлтөнд тусламж үзүүлж, амаржих газар тээвэрлэсэн ба гэрийн төрөлттэй холбоотой эмч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, аргачлал зөвлөмж гарган ажиллаж байна. Шалтгаан нь тулгаж дуудсан, амаржих буцаасан, замын түгжрэлтэй холбоотойг судалгаа хийж Нийслэлийн онол практикийн чуулганд илтгэл тавьсан.
2. 0-5 хүртэлх насны эндэгдэл: 2019 онд 0-5 насны хүүхдийн 70 тохиолдол байсан ба 2018 оны мөн үед 4 тохиолдлоор нэмэгдсэн. Эндэгдлийн байдлаас 47 өвчлөл, 3 шалтгаан тодорхойгүй, 20 осол гэмтлийн шалтгаантай байна.
3. Нялхсын эндэгдэл 0-28 хоногтой нярайн эндэгдэл 2019 оны жилд 8 гарсан ба өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор нэмэгдсэн.


#### б/Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /2017-2026 он/

Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолд тусгагдсан зорилго



1. Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулах, түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгах, алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд:

Д/Д	Үндсэн үзүүлэлт	2018 он		2019 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
A	<b>Нийт дуудлага</b>	<b>303275</b>	<b>100%</b>	<b>312146</b>	<b>100%</b>	<b>8871</b>	<b>2.8%</b>
Үүнээс	Насанд хүрэгчдийн дуудлага	267928	88.3%	271429	87.0%	3501	-1.3%
	Хүүхдийн дуудлага	35347	11.7%	40717	15.0%	5370	3.3%
хүрэгчдийн дуудлага	Үр дүнгүй дуудлага	13906	5.2%	13300	4.9%	-606	-0.3%
	Төрөх	19789	7.4%	18728	6.9%	-1061	-0.5%
	Осол гэмтэл	48310	18.0%	52018	19.2%	3708	1.2%
	Өвчлөл	185923	69.4%	187383	69.0%	1460	-0.4%
B	<b>Яаралтай дуудлага</b>	<b>208213</b>	<b>77.7%</b>	<b>216313</b>	<b>79.7%</b>	<b>8100</b>	<b>2.0%</b>
<b>20 минутын очилт</b>		<b>180206</b>	<b>86.5%</b>	<b>184941</b>	<b>86,6%</b>	<b>4735</b>	<b>-1.0%</b>
C	Гэрийн төрөлт	129	0.7%	83	0.4%	-46	-0.3%
D	Нас баралт /нийт/	2712	1.0%	2928	0.3%	-1793	-0.7%
Зүрхний шигдээс		3631	1.4%	2902	1.1%	-729	-0.3%
Тархины цус харвах		498	0.2%	320	0.1%	-178	-0.1%
Даралт ихдэх		32044	12.0%	31932	11.8%	-112	-0.2%
Хоол шингээх эрхтэний бусад		7576	2.8%	5601	2.1%	-1975	-0.7%
Умайн цус алдалт		247	0.1%	176	0.1%	-71	0.0%
Амьсгалын замын цочмог халдвар		11034	4.1%	12740	4.7%	1706	0.6%
Бөөр шээсний замын бусад		9292	3.5%	8608	3.2%	-684	-0.3%
Халдварт өвчин		846	0.3%	546	0.2%	-300	-0.1%
Хорт хавдар		5114	1.9%	5769	2.1%	655	0.2%
Сэтгэцийн өвчлөл		1063	0.4%	1079	0.4%	16	0.1%
Бусад		114578	42.8%	117710	43.4%	3132	0.6%

Дүгнэлт:2019 онд нийт дуудлага 2,8%-иар нэмэгдсэн. Хүүхдийн дуудлага өмнөх Оноос 3,3%-иар өссөн. Осол гэмтлийн дуудлага 1,2-иар, амьсгалын замын өвчлөл 0,6%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



Дүгнэлт: Гэрийн төрөлт өмнөх оноос 55.4 хувиар буурсан. Нас баралт 0,1%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




Яаралтай дуудлагын тоо өмнөх үеэс 0.7%-иар нэмэгдэж 20 минутын очилт 0,1%-иар өссөн байгаа нь дуудлагын тоо нэмэгдсэн ч өдөрт гарах автомашины тоог нэмэгдүүлэн ээлжийн ахлагч, зохицуулагч нарын ур чадвар , дуудлагын эмч нарын шуурхай байдалтай холбоотой сайн үзүүлэлт юм.

**Дүгнэлт:** Хүүхдийн дуудлага өмнөх оны мөн үеэс 5384 буюу 13,1%-иар өссөн. Явж үзсэн дуудлага 5370, амбулаториор ирж үзүүлэгсэд 14-өөр нэмэгдсэн. Өвчлөлөөр задалж үзэхэд нярайн эмгэг 0,6%, мэдрэлийн эмгэг 0,7%, амьсгалын замын эмгэг 0,2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Халдварт өвчин буурч, бусад өвчлөл нэмэгдсэн.


*ТТТөвийн 2019 оны жилийн эцсийн хүүхдийн дуудлагыг өмнөх  
оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт*

д/д	Үндсэн үзүүлэлт	2018 он		2019 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>A</b>	<b>Салбаруудын нийт хүүхдийн дуудлага</b>	<b>35405</b>	<b>100%</b>	<b>40789</b>	<b>100%</b>	<b>5384</b>	<b>13.1%</b>
Үүнээс	Явж үзсэн дуудлага	35347	99.9%	40717	99.8%	5370	0.1%
	Амбулатор	58	0.1%	72	0.2%	14	0.1%
	Утсаар зөвөлгөө өгсөн	216709		223890		7181	58.5%
	Яаралтай дуудлага	6937	19.7%	6809	16.7%	-128	-3.0%
	20 минутын очилт	6395	92.9%	6409	94.1%	14	1.2%
<b>B</b>	<b>Өвчлөл</b>	<b>35347</b>	<b>91.8%</b>	<b>40694</b>	<b>96.0%</b>	<b>5347</b>	<b>4.2%</b>
Үүнээс	Нярайн эмгэг	1735	4.9%	1761	4.3%	69	0.6%
	Мэдрэлийн эмгэг	3154	8.9%	3331	8.2%	177	0.7%
	Амьсгалын замын эмгэг	19479	55.1%	22504	55.3%	3025	0.2%
	Хоол боловсруулах замын эмгэг	3457	9.8%	4512	11.1%	1055	1.3%
	Мэс заслын эмгэг	369	1.0%	428	1.1%	64	0.2%
	Халдварт өвчин	499	1.4%	389	1.0%	109	0.3%
	Бусад өвчин	6654	18.8%	7769	19.1%	1864	8.7%

### Салбаруудын хүүхдийн дуудлагын үзүүлэлт



### Нярайн өвчлөлийн үзүүлэлт



ТТТөвийн 2019 оны жилийн эцсийн эмнэлгийн тусламж үйлчилгээний өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт


Эмнэлгийн тусламж үйлчилгээ	2018 он		2019 он		Харьцуулалт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь

Нийт дуудлага		303275	100%	312146	100%	8871	2.8%
<b>A</b>	<b>Осол гэмтлийн дуудлага</b>	<b>48310</b>	<b>15.9%</b>	<b>52018</b>	<b>16.7%</b>	<b>3708</b>	<b>0.8%</b>
Шархны анхны цэгцэлгээ		4012	8.3%	4213	8.1%	201	-0.2%
Боолт		4808	10.0%	5084	9.8%	276	-0.2%
Чиг		723	1.5%	828	1.6%	105	0.1%
Новокайны хориг		331	0.7%	210	0.4%	-121	-0.3%
<b>B</b>	<b>Зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэг</b>	<b>36173</b>	<b>11.9%</b>	<b>35154</b>	<b>11.3%</b>	<b>-1019</b>	<b>2.9%</b>
ЭКГ		83	0.2%	106	0.3%	23	0.1%
ЗСА сэхээн амьдруулалт		128	0.4%	142	0.4%	14	0.0%
Хүчилтөрөгч өгсөн		4642	12.8%	4236	12.0%	-406	-0.8%
Шингэн залгасан		607	1.7%	730	2.1%	123	0.4%
<b>C</b>	<b>Бусад өвчлөл</b>	<b>218792</b>	<b>72.1%</b>	<b>224974</b>	<b>72.1%</b>	<b>6182</b>	<b>2.7%</b>
Судас тариа		18591	8.5%	20938	9.3%	2347	0.8%
Бусад тариа		18566	8.5%	24853	11.0%	6287	2.5%
Эмнэлэгт хүргэсэн		40487	18.5%	47244	21.0%	6757	2.5%
Бусад хэлбэрийн		197740	90.4%	208153	92.5%	10413	2.1%

Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад осол гэмтлийн үед үзүүлэх тусламж 0,2%-иар өссөн, зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэгийн үед үзүүлэх тусламж 2,9%-иар буурсан үзүүлэлттэй байна.


### Осол гэмтлийн үеийн тусламж

■ 2018 он ■ 2019 он




### Зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэгийн үеийн тусламж

■ 2018 он ■ 2019 он







ТТТөвийн дуудлагын хүлээгдэлийг өмнөх оны мөн үетэй  
харьцуулсан үзүүлэлт



Үзүүлэлт		2018 он		2019 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт дуудлага		279838	100%	308788	100%	28950	9.4%
Хүлээгдэлийн минут	0-20 минут	105540	37.7%	108987	35.3%	3447	-2.4%
	21-40 минут	86529	30.9%	103419	33.5%	16890	2.6%
	41-60 минут	48886	17.5%	54265	17.6%	5379	0.1%
	61-с дээш минут	38883	13.9%	42117	13.6%	3234	-0.3%

в/ Нийгэм эдийн засгийн зорилтууд

- 4.2.12. Дүүргийн түргэн тусламжийн төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэн, автомашины парк шинэчлэлт хийж, дуудлагын 20 минутын доторх очилтыг нэмэгдүүлнэ.
- 4.4.3. “Улаанбаатар Марафон” олон улсын гүйлтийн тэмцээн, Нийслэлийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулах
- 4.2.7.Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.
- 4.1.16.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил зохион байгуулах
- 4.4.5. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан олон талт арга хэмжээнүүд зохион байгуулах
- 2.4.23. Гамшгийн эрсдлийн үнэлгээ болон төлөвлөгөөнд тодотгол хийх
- 3.3. Хот тохижилт ногоон байгууламжийн талаар

г/Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаанд тусгагдсан хөрөнгө оруулалтын ажлуудаас

Тус төвийн Чингэлтэй салбарын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ажил Чингэлтэйн 14 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Хайлаастын гудамжид барихаар “Комптрейд” ХХК холбогдох газарт шалгарч барилгын ажил баригдаж эхэлсэн. Тухайн салбарт хамаарах 26 хорооны дуудлагын тоо, өвчлөлийн судалгаа гарган 2019 оны 12 сарын 15 наас 4 эмч, жолооч, зохицуулагчийн хамтаар үйл ажиллагаа явуулснаар дуудлагын хүлээгдэл 12 хувь буурч, яаралтай дуудлагын 20 минутын очилт 2 орчим хувиар нэмэгдэх төлөлтэй байна.



д/Нийгэм эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу сарын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.


4.2.12. Дүүргийн түргэн тусламжийн төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэн, автомашины парк шинэчлэлт хийж, дуудлагын 20 минутын доторх очилтыг нэмэгдүүлнэ.

- Дуудлагын тоо, өвчлөлтэй уялдан дуудлагын эмч, автомашины тоог нэмэгдүүлэх, салбар хооронд уялдаатай ажилласнаар яаралтай дуудлагын 20 минутын очилт 0.1 хувиар нэмэгдсэн.

Нийслэлийн засаг даргын А/88 дугаар захирамжын дагуу нийслэлийн түргэн тусламжийн төвийн автомашинуудад хяналтын GPS систем нэвтрүүлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газраас зарласан тендэрт VanqTech ХХК сонгогдож нийт 75 сая төгрөгийн үнэтэй “GPS хяналтын цогц системийг” нэвтрүүллээ. Уг байршил тодорхойлох систем нь Google Map-ийн газрын зураг дээр харуулдаг ба E1N /Emergency Information Network/ програмтай холбогдож ажилладаг.

Нийт 85 автомашинд “Meitrack T366” загварын хяналтын GPS суурилуулсан ба мэдээллийг үүрэн холбооны сүлжээгээр хяналтын серверлүү дамжуулан төв болон салбаруудад хяналт тавин ажиллаж байна.

GPS программыг нэвтрүүлснээр дотоод хяналт сайжирч, жолоочийн тооцоо, эмнэлэг үйлчилгээнд үйлчлэх автомашинуудын шуурхай байдал нэмэгдсэн.




- Автомашины нөхөн хангалтын талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх хүрээнд автомашины нөхөн хангалт, түргэн тусламжийн зориулалтын автомашины судалгааг гарган зохих шатны байгууллагад хүргүүлсэн.

Нийслэлийн засаг дарга болон Улаанбаатар хотын захирагчийн хөрөнгө оруулалтаар Форд Транзит маркийн 3 автомашин, Монгол Улсын эрүүл мэндийн яам, Япон улсын элчин сайдын яамнаас хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн түргэн тусламжийн автомашинаар хангах төсөл”-ийн хүрээнд Тоёота Хайсе маркийн 3 автомашиныг тус тус хүлээлгэн өгсөн. Уг автомашинууд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, ашиглалтын хугацаа дууссан, түүнчлэн нэмэлтээр шаардлагатай байгаа автомашины хэрэгцээ шаардлагыг хангасан томоохон хөрөнгө оруулалт болсон.



### **Парк ашиглалтын коэффициент, Техникийн бэлэн байдлын коэффициент:**

Автобааз нийт 123 жолооч 87 автомашинтайгаар эмнэлэг үйлчилгээний байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Өдөрт 45-48 автомашин эмнэлэг үйлчилгээнд ажиллаж, Парк ашиглалтын коэффициент 58 хувь, Техникийн бэлэн байдлын коэффициент 91хувьтай байна. 2018 оноос 7 хувиар буурсан нь 2 автомашин 2-3 сар их засварт орсон тул техникийн бэлэн байдлын коэффициент 7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



- Автомашины эмнэлгийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, хяналтыг тогтмолжуулах хүрээнд автомашинд суурилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа болон ажиллагааны бэлэн байдлын хяналт шалгалтыг төлөвлөгөөт үзлэг үйлчилгээний дагуу 7 хоногт 1 удаа хийж тогтмолжуулсан. Хяналт, аюулгүй ажиллагааг үнэлэн, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэн ажилласнаар цаг тухай бүрд нь тоног төхөөрөмжийн оношилгоог хийж засварлан тоног төхөөрөмжийн найдвартай үйл ажиллагааг ханган ажилласан. Ингэснээр эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа уртсан доголдолгүй болсон.
- 2019 оны Автотээврийн хэрэгслийн улсын үзлэг тооллогод эмнэлэг үйлчилгээнд үйлчилдэг 80 гаруй автомашиныг бүрэн хамруулж, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техникийн ашиглалтын шаардлага хангасан байдалд техникийн хяналтын үзлэг хийлгэж, хангалттай үнэлгээ авсан.



### **2. Чанарын өдөрлөг, аян чанаржуулах ажлуудыг зохион байгуулах хүрээнд чанарын өдөрлөг:**

2019 онд чанарын тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 19 ажил төлөвлөж, 100% -тай биелэгдэж байна. Гарсан зөрчлийн хувьд: дэвтэр хөтлөлт хангалтгүй,

ариун цэвэр, өнгө үзэмж сайжруулах, энгэрийн тэмдэг зүүж хэвших, эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэнэглэлт, хадгалалт, хамгаалалт зэрэг зөрчлүүд гарсан.

Дотоод хяналтыг сар бүр хийснээр эмнэлэг үйлчилгээнд үйлчилж буй өнгө үзэмж сайжирч, жолооч нарын ажилдаа хандах хандлага, хариуцлага нэмэгдэж байна.

Чанарын өдөрлөг 3 дугаар сарын хугацаанд Эмчийн тангаргийн ёслол хийгдэж, сайн үйлсийн аян, сайн ажилласан зарим эмч нарыг шагнаж урамшуулах, 4 дүгээр сард төрсөн эмч нарын төрсөн өдрийг тэмдэглэж, чанарын шилжин явах цомын баярын үйл ажиллагаа, зохион байгуулж, ажилласан. 197 эмч ажилчид оролцсон. Чанарын өдөрлөг 6-ийг зохион байгуулж, нийт 425 эмч ажилтан /давхардсан тоогоор/ оролцсон.

- “Менингококкт халдвараас урьдчилан сэргийлье, ТТТӨ-өөс урьдчилан сэргийлье”, “Улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлье” аянаар 4 дүүргийн 7 цэцэрлэг, 5 сургуулийн хүүхэд, багш асран хамгаалагч нарт сургалт мэдээлэл, тараах материал 550 ширхэг өгсөн.
- Олон улсын эмч нарын өдрийг угтан чанарын албанаас “Чанарын өдөрлөг” зохион байгуулж, 2019 оны 03 дугаар сарын 30-ны хүндэтгэлийн үйл ажиллагаанд жолооч нарын төлөөлөл, сувилахуйн алба, дуудлагын 103 эмч оролцлоо.

Ажил мэргэжлээрээ бусдыгаа тэргүүлсэн 47 их эмчийг шагнаж урамшууллаа., эмч мэргэжлээрээ бахархах, эмчийн ёс зүй, харьцаа хандлага сайжирч, ажилдаа идэвх зүтгэлтэй ажиллах урам зориг өгсөн үйл ажиллагаа болж өнгөрлөө.



“Цэвэр гар амь насыг аварна” сэдэвт өдөрлөгийг 2019 оны 5-р сарын 03-ны өдөр салбар дээр зохион байгуулсан. Тус өдөрлөгт Хан-Уул салбарын 3-н ээлжийн нийт 20 эмч, сувилагч, тогооч, үйлчилгээний ажилчид 100% идэвхтэй оролцсон. Мөн автобааз дээр 82 жолооч нар сургалтад хамрагдан суусан.

Өдөрлөгийн үеэр нийт ажилчдаас гар угаах стандартаар шалгалт авч, эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх, эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх 186, 187 тоот тушаалын дагуу “Гарын эрүүл ахуй” сэдэвт сургалт явуулж, гарын эрүүл ахуйн талаарх үзүүлэн гарын авлага, сурталчилгааны материал тараасан.

**Дүгнэлт:** Нийт ажилчдын эрүүл ахуйн зөв соёлыг хэвшүүлэн, гарын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл ахуйн мэдлэг олголоо.

Чанарын албанаас зохион байгуулсан 04 дүгээр сарын 26-ны өдөр автобаазын гадна талбайд нийт 68 жолооч болон удирдлагын багийн бүрэлдэхүүнтэй тэмдэглэлээ. Энэ өдөрлөгийн арга хэмжээнд дуудлагын жолооч болон авто

машины бэлэн байдлыг үйлчлүүлэгчид үзүүлэх эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг сайжруулах зорилготой хийсэн.

Үүний үр дүнд дуудлагын жолооч үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээ нь сайжирч, эмнэлгийн тоног төхөөрөмжийг бүрэн ажиллуулах болон авто машины халдваргүйтгэл, цэвэрлэгээг зөв хийх аргачлалыг үзүүлэх сургалт хийж харуулсан үр дүнтэй өдөрлөг болсон.

- “Инээмсэглэл эелдэг харьцаа” сэдэвт 1 сарын аяныг 3 дугаар сард Баянзүрх салбартай хамтарч зохион байгуулсан. 03 дугаар сарын 13-21 хүртэл “Ажлын байрны стресс” мэдээлэл сургалтыг бүлгийн ярилцлага хэлбэрээр орж, ажлын байрны стрессийг үнэлэх асуумж, судалгааг нийт 59 эмчээс авч, үр дүнг нэгтгэсэн. Дээрх сургалтыг Төв, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх салбарын нийт 108 эмчид орсон. Үүний үр дүнд иргэдээс ирэх гомдлын тоо буурч, талархал өссөн үзүүлэлт гарсан.

“Баянзүрх салбарын хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах” 1 сарын аян зохион байгуулсан. Үүгээр утсаар харилцах эмнэлзүйн тохиолдлыг гаргаж, түүн дээр суурилсан сургалт зохион байгуулсан. Мөн зохицуулагч нарын хүлээгдэл дээр хэлэлцүүлэг, гэрийн төрөлтийн дуудлагын хуудсанд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хүүхдийн дуудлагын хуудсан дээр хяналт хийсэн, ажлын байрны бэлэн байдалд үнэлгээ хийсэн.

03 дугаар сард Дэхийн эмч нарын өдрийг угтсан эмч нарын дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулсан.



**Чанарын аян-7** Тус төвөөс 7 аян зохион байгуулсан. Хамрагдсан хүний тоо 452.

Сувилагчийн нэг өдрийн сайн үйлсийн аянаар АСТ ажил мэргэжлийн уралдаан, 2019 оны 04 дүгээр сарын 10-15-ны хооронд дүүргүүдийн өрхийн эмнэлгүүдэд 0-5 настай хяналтад байгаа хүүхдүүдийн эрсдлийн үнэлгээг хийсэн. Судалгаанд нийт 153 хүүхэд хамрагдсан.

“Менингококкт халдвараас урьдчилан сэргийлье, ТТТӨ-өөс урьдчилан сэргийлье” аянаар

дүүргийн 7 цэцэрлэг, 5 сургуулийн хүүхэд, багш асран хамгаалагч нарт сургалт мэдээлэл, тараах материал 550 ширхэг өгсөн.

“Хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлье, томуу, томуу төст өвчнөөс хамтдаа сэргийлье” аянаар 15 эмчийн 38,0 дуудлагын хуудас үнэлгээ хийж, хэлэлцүүлэг зохиосон. Ингэснээр Хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, газар дээрх болон эмнэлэг хүртэлх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах, дуудлага хүлээн авах болон дуудлагын хуудас бичилт сайжирсан.

Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулж гомдлыг бууруулах аянаар БЗС-т дотоод хяналтаар хянан явуулсан. Тус салбарын 28 их эмч оролцсон. Тус салбарын эмч нарын ур чадвар, мэдлэг боловсрол сайжирсан.

### 1. ХӨЦМ-ийн эмнэлзүйн шинэчилсэн сургалт:

- “Хүүхдийн өвчний цогц менежмент”-ийн эмнэл зүйн шинэчилсэн сургалтыг 2019 онд шинээр ажилд орсон 45 эмч, 8 сувилагч нийт 53 эмч мэргэжилтэн нарт 10 дугаар сарын 28-аас 11 дүгээр сарын 09 хүртэл 12 хоногийн хугацаанд нар нийт 96 цагийн сургалтад хамрагдан суусан.
- Амбулаторийн (ширээний) дадлага хичээлийг Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв, Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны эрүүл мэндийн төв дээр тус тус хийсэн. Мөн 0-5 насны хүүхдийн дуудлагад үзлэг зөвлөгөөг хийсэн.




- Сургалтын өмнөх болон дараах онолын мэдлэгийн үнэлгээ хийсэн. Хангалтгүй 65.2% сургалтын өмнө байсан бол сургалтын дараа 15.2% болж буурч, ХӨЦМ-ийн онолын мэдлэг 50.7%-аар сайжирсан чанарын үзүүлэлт харагдаж байна.

Үр дүн: ХӨЦМ-ийн хэрэгжилт, 0-5 насны хүүхдийн тусламж үйлчилгээ, хүүхдэд зөвлөгөө өгөх чадвар, ХӨЦМ-ийн онолын мэдлэг 50.7%-аар сайжирсан.



1. **Ур чадварын үнэлгээ:** Эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу чанар хүртээмжтэй үзүүлэх, чадварлаг багийг (Эмч, сувилагч, жолооч нарын баг, эмч, жолооч нарын баг, дагалдан эмч, жолооч нарын баг) мэргэжлийн түвшинд сургах, дадлагажуулах, үнэлэх зорилгоор 2019 оны 10, 11 дүгээр сард зохион байгуулагдсан. Үнэлгээнд 2018, 2019 онд шинээр ажилд орсон нийт 98 эмч, дагалдан эмч, сувилагч, жолооч буюу 85.9% нь хамрагдсан.
2. Ур чадварын үнэлгээг онол болон өртөөчилсэн гардан үйлдэл, багаар ажиллах чадвар гэсэн 3 чиглэлээр авсан. Эх барих, хүүхдийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж, амиллуулах, яаралтай тусламжийн эмийн сорил, тоног төхөөрөмж, түгээмэл үйлдлийн стандарт, гар халдваргүйжүүлэлтээр онолын болон гардан үйлдэл эмнэлзүйн тохиолдол өгч ажиллуулсан.



Үр дүн: Ур чадварын үнэлгээ шалгалтыг тогтмол зохион байгуулах, эмч нарын бэлэн мэдлэг хангалтгүй, өөрийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, дадал сурах шаардлагатай байгаа нь ур чадварын үнэлгээнүүдээс харагдаж байна.

### 3. “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөө дуу хоолойгоо нэгтгэцгээ” өдөрлөг:

Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас санаачлан хэрэгжүүлж буй “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөө дуу хоолойгоо нэгтгэцгээ” урианы дор үйлчлүүлэгчид, иргэд, эрүүл мэндийн мэргэжилтнүүд оролцсон өдөрлөг, мөн “Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, өдөрт 10000 алхам-цэвэр агаар-хандлагаа өөрчилье” аяныг дэмжиж, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын ач холбогдлыг сурталчлах, мэдлэг хандлагыг дээшлүүлэх зорилготойгоор зорилтот өдөрлөгийг Чингисийн өргөө цогцолборын гадаа, Богд-Уул Дугуй цагааны энгэрт, 09 дугаар сарын 28-ны Бямба гаригт 10 цагаас 15 цаг хүртэл, нийт 5 цагийн үйл ажиллагаа зохион байгууллаа.



- Сурталчилгааны тараах 20 чиглэлийн 750 материал бэлдэж, иргэдэд тараасан.
  - Богд-Ууланд алхалт хийж буй нийслэлийн 495 иргэдэд артерийн даралт, захын судасны хүчилтөрөгчийн ханамж, зүрхний цохилтын тоо, амьсгалын тоо зэрэг амин үзүүлэлтийг үзэж, зөвлөмж, тараах материал тараасан.
  - Биеийн жин үзэж, биеийн жингийн индексийг 163 хүнд хийж эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн. Үүнээс эрэгтэй 52, эмэгтэй 111 хүн оролцсон. Насаар нь ангилбал 16-аас доош 4, 17-25 насны 16, 26-45 насны 97, 46-аас дээш насны 46 хүн байсан.
  - Цусны сахрыг эрсдэлтэй гэсэн 200 иргэнд хэмжиж, эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.
- Өдөрлөгт оролцож байгаа иргэд болон байгууллагын ажилчдад халуун цай, кофе, аньс, чацаргана, нэрсний шүүс, цайны печень, сандвичээр үйлчилсэн.
- Уулнаас дугуйтай бууж унаж гэмтсэн 1, уулнаас бууж байхдаа хөлөө гэмтээсэн 1 хүнд яаралтай анхны тусламж үзүүлж боолт, чиг тавьсан.
  - Иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг арга хэмжээнд оролцсон иргэдээс гурван асуумжтай судалгаа явуулсан. Судалгаанд нийт 185 хүн оролцсон.



#### 4. Сайн туршлага-2019:

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээнд тэргүүн туршлага, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Сайн туршлага” арга хэмжээ 2019 оны 10 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулагдсан. 4 чиглэлээр 9 бүтээл оролцуулсан. Үүнд:

- “Эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах, аюулгүй байдлыг шийдвэрлэн ажилласан бүтээл”-д 2 сайн туршлага
- “Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бүтээл”-д 1 сайн туршлага
- “Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологи”-д 2 сайн туршлага
- “Шинээр боловсруулсан ном товхимол, удирдамж, гарын авлага, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр”-д 4 бүтээлээр оролцов.

Байгууллагын 272 бүтээл оролцоноос тус төв 9 батламж, “Яаралтай тусламжийн ампултай тарианы цүнх” бүтээл 2019 оны “Сайн туршлага 2019”-ын шилдэг 20 бүтээлийн нэгээр шалгарч гэрчилгээгээр баталгаажуулсан.

№	Сайн туршлагын нэр
1	Эмнэлгээс шалтгаалах халдвараас урьдчилан сэргийлэх автомашины явуулын “Асгарсан, цацагдсан, цус, органик бохирдол цэвэрлэх цомог”
2	Монгол заавартай Автомат тохируулгатай дефибриллятор, зүрхийг автоматаар сэдээгч (ЗАС) аппарат
3	<b>Яаралтай тусламжийн тарианы цүнх</b>
4	Гамшгийн нэн шаардлагатай хээрийн эмнэлэг, майхан
5	Автомашины гадна талд иргэдэд замын хөдөлгөөнд оролцоход анхааруулсан санамжийн “Маргааш танд хүрэхийн тулд өнөөдөр та зам тавьж өгөөрэй” стикер наалт
6	Автомат тохируулгатай дефибриллятор, зүрхийг автоматаар сэдээгч (ЗАС)-д тавих ерөнхий шаардлага” Монгол улсын стандарт удирдамж
7	Түргэн тусламжийн үйл ажиллагааны стандарт MNS6717:2018 стандарт удирдамж
8	Чанарын сургалтын материал CD
9	Алдаанаас суралцацгаая, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээний талаар сургалтын материал, CD

Үүнээс “Яаралтай тусламжийн тарианы цүнх” шилдэг 20 бүтээлийн нэгээр шалгарч батламж авсан.



## Үзүүлэх сургууль-2

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам батлах” тухай 339 дүгээр тогтоол, 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам батлах” тухай 340 дүгээр тогтоол, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирлын 2019 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн А/14 дүгээр тушаалын дагуу “Гамшгаас хамгаалах дадлага, сургалт”-ыг 2019 оны 03 сарын 21-ны 16.00 дуут дохиогоор “Суу, нуугд, хүлээ” алхмын дагуу гүйцэтгэж дарааллын дагуу аюулгүй цэгт цугларсан. Дуудлагад үйлчилж буй 16 эмнэлгийн тоноглогдсон автомашин 1 минутын турш дуут дохиогоо дуугаргасан. Штабын дарга дэд захирал С.Ариунболд зохион байгуулан, штабын дэд дарга М.Цэрэнчимэд бүртгэл хөтлөн ажилласан. Ажиллаж байсан нийт 56 ажилтан, ажиллагсад 100 хувийн ирцтэйгээр оролцов. Мөн гамшгийн үед ажиллах мэргэжлийн ангийн талаар 10 минутын сургалт хийсэн. Гамшгийн үзүүлэх сургалтын үр дүн нь нийслэлдээ 3 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлсэн.

Автомашиньг хоёр хувингийн аргаар ариутгаж, халдваргүйжүүлэх үзүүлэх сургалтыг 2 дугаар сарын 26-28-ний өдрүүдэд нийт 84 жолоочийн 3 цагийн сургалтад хамруулсан. Сургалтыг Герман улсын Эссэн хотын гал унтраах ангитай туршлага солилцон ажилласан шалгах механик В.Түвшиндэлгэр, 2-р ээлжийн техникийн ажилтан Ц.Эрдэнэбадрах нар нэг автомашиныг 50 минутын хугацаанд бүрэн ариутгаж, үзүүлэх сургалтыг амжилттай зохион байгууллаа.

## Эмнэлзүйн сургалт-5

НЭМГ-аас зохион байгуулсан “Хүүхдийн өвчний цогц менежмент”-ийн эмнэлзүйн сургагч багш бэлдэх сургалтад хүүхдийн эмч, чанарын менежер З.Энхцэцэг, Сонгинохайрхан салбарын эрхлэгч Ш.Нармандах нар 2019 оны 02 дугаар сарын 25-аас 03 дугаар сарын 02 хүртэл хугацаанд Нийслэлийн түргэн тусламжийн төвийн сургалтын танхимд зохион байгуулагдаж, түүнд хамрагдсан. Сургалтыг үндэсний сургагч багш АШУҮИС-ийн хүүхдийн тэнхимийн зөвлөх багш Д.Даваасүрэн, Б.Бадамханд нар заасан. Дадлага сургалтыг Баянзүрх дүүргийн 25 дугаар хорооны “Энх-Агшин” ӨЭМТ, 16 дугаар хорооны “Сугар-Энх” ӨЭМТ-үүдэд хийсэн.



**Хүүхдийн эндэгдлийн эмнэлзүйн хэлэлцүүлэг-4** Оролцсон эмч нар эмнэлзүйн тохиолдол тус бүр дээр хэлэлцэн ярилцсан. Үүнд:

Зовиур, асуумж, өвчний түүх авалт, нас барсан шалтгаан  
Үзлэгт нас барсан байдлыг тодорхойлсон байдал  
Нас барсныг тодорхойлсон, шийдвэрлэсэн байдал  
Дуудлагын хуудас бичилт  
Тус дуудлагын хуудсанд илэрсэн алдаануудыг өөрсдөөр нь хянуулж  
Тухайн хүүхэд нас барсан эрсдлийг гаргаж тайлбарлах  
Эрсдлийг бууруулах талаар ямар ажлуудыг хийх вэ зэрэг байдлаар  
хэлэлцүүлэг явагдсан.

Эндэгдэл тохиолдлын дүгнэлтийг үндэслэн магадлан хэлэлцэж, нотолгоонд суурилсан аргачлал зөвлөмж боловсруулан гаргасан.

**Гэрийн төрөлтийн эмнэлзүйн хэлэлцүүлэг-** 2019 оны 01 дүгээр улиралд тохиолдсон гэрийн төрөлтийн дуудлагын хуудас болон дуудлагад очсон эмч нар хэлэлцүүлэгт оролцсон. Эндээс зөвлөмж боловсруулан, гаргасан алдаа зөрчлүүдийг хэлэлцэн, дахин алдахаас сэргийлсэн, дуудлагын хуудас бичилт сайжирсан.

**Дуудлагын хуудас бичилтэд хэлэлцүүлэг-** Сүүлийн 3 сард ажилд шинээр орсон 26 эмчийн осол, төрөх, бусад өвчлөлийн 75 дуудлагын хуудсан дээр эмнэл зүйн хэлэлцүүлэг /дуудлагын хуудасны журмын/ хийхэд хангалттай буюу 38.4%, хангалтгүй буюу 61.6% байна.

2019 оны 01 дүгээр сарын 30-нд “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчний үеийн асаргаа сувилгаа, тууралтат халдварт өвчнүүдийн ялган оношилгоо, томуугийн үед үзүүлэх сэргээн засах эмчилгээ” сэдэвт сургалтад нийт 18 сувилагч 100% хамрагдсан.



Эрүүл мэндийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 29-ны №09 тоот албан даалгавар, 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/07, А/09 тушаалууд, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 07-ны А/02 зэрэг томуу томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зохицуулах зорилгоор насанд хүрэгчдийн зарим эмнэлэг үйлчилгээнд түр өөрчлөлт гарсныг дуудлагын эмч, сувилагч нарт танилцуулж судлуулж, тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхийг анхааруулж ажиллаж байна.

2019 оны 02 дугаар сарын 21 нд ЭМЯ-ны дэвшүүлсэн “1:2” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагад ажиллах

сувилагчийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр 2019 оны 02 дугаар сарын 22 нд зохион байгуулсан уулзалт ярилцлагад сувилахуйн албаны дарга, хүний нөөцийн мэргэжилтний хамт оролцсон.

2019 оны 03 дугаар сарын 01-нд Эрүүл мэндийн газраас зохион байгуулагдсан “Төсөл бичих аргачлал болон эрдэм шинжилгээний ажлыг хэрхэн хийх” талаарх сургалтад 1 сувилагч хамрагдсан. Энэ сургалтад хамрагдсанаар сувилагч, тусгай мэргэжилтний судалгааны ажил хийхэд болон төсөл боловсруулж сурахад мэдлэг олгосон тустай ажил болсон.

2019 оны 05 дугаар сарын 10-нд ЭМЯ, МСН, Сувилахуйн амьдрал төв хамтран зохион байгуулсан “Сувилахуйн удирдах ажилтны зөвлөгөөн”-д 1 ахлах сувилагч оролцож 21 аймаг, орон нутгаас хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгч нартай туршлага солилцож хамтран ажилсан.



2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Интермед эмнэлгээс зохион байгуулсан “Эмнэлгийн сувилахуйн тусламжийн зохион байгуулалт” сэдэвт сургалтад 1 сувилагч оролцсон.

2019 оны 05 дугаар сарын 29-нд “Монос” группээс зохион байгуулсан эмийн шинэ үйлдвэртэй танилцах аялал, сургалтад 1 эмийн санч амжилттай оролцсон.

### Чанарын судалгаа -15.

- Сувилахуйн алба нь чанарын албатай хамтран 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдөр “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ-Инээмсэглэл эерэг хандлага” сэдвийн дор эрдмийн чуулганд 12 илтгэл оролцож, тусламж үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлуудаар зохион байгуулсан. Судалгааг эмч 35, сувилагч 6, жолооч 2 нийт 43 ажилтан хамтран хийсэн байна.

Тус төвийн шилдэг илтгэлүүд:



- Нийслэлийн Эрүүл мэндийн газраас “Эрдэм шинжилгээний хурал-2019” арга хэмжээг 11 дүгээр сарын 11-нд зохион байгуулсан. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг тус арга хэмжээний хүрээнд Эрдмийн чуулга, онол практикийн

бага хуралд тус төвөөс 2 аман илтгэл оролцож, Нийслэлийн түргэн тусламжийн төвийн ээлжийн ахлагч их эмч З.Баярсайхан “16 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн онцлог, тусламж үйлчилгээний зарим асуудал” сэдвээр оролцож НЭМГ-ын байгууллагуудаас тэргүүн байр эзэллээ.



- НТТТөвийн их эмч З.Баярсайхан ахлагчтай судалгааны багийн “Нийслэлийн Түргэн Тусламжийн төвд хандсан 16 хүртэлх насны хүүхдэд тохиолдож буй осол гэмтлийн онцлог” сэдэвт илтгэл АШУҮИС-н 61 дэх удаагийн эрдмийн чуулганд АУС-н салбар хуралдаанд “Ханын Илтгэл”-ийн төрөлд тэргүүн байр, НЭМ-н салбар хуралдаан “Шилдэг илтгэл”-ээр шалгарлаа.
- "Ажлын байрны стресс"-ээр 59 эмч, ажилчдын дунд судалгаа хийж гаргасан.ажлын байрны стрессийг үнэлэхэд хамгийн бага стресстэй 11 /18.6%/, стрессийн анхан шат-28 /47.4%/, дунд зэргийн стресстэй 16 /30.5%/, хамгийн хүчтэй стресстэй 4 /6.7%/ гэж гарсан. Ингэснээр эмч, сувилагч, жолооч нарт иргэдээс ирж байгаа талархал нэмэгдэж, гомдол санал буурч ажиллаж байна.
- Тус төвд бүртгэгдсэн 0-16 насны хүүхдийн гэрийн нас баралтын судалгааг улирал тутам гаргаж байна.

#### **Хэлэлцүүлэг-4, Клиник разборын тоо-35 удаа, 17 чиглэлээр, 668 эмч/давхардсан тоо/ хамрагдсан.**

- Төвөнхийн цочмог бачууралт үрэвслийн зэргээр ангилах, оношлох, үзүүлэх тусламж үйлчилгээ, өгөх зөвлөгөөний талаар сургалтыг Баянзүрх салбарын 1, 2, 3 дугаар ээлжийн дуудлагын 33 эмч, оператор 6 эмч, сувилагч 6, эмийн санч 3 нийт 48 эмч, сувилагч нар тохиолдолд суурилсан сургалт хичээлийг 2019 оны 04 дүгээр сарын 19-өөс 2019 оны 04 дүгээр сарын 24 хооронд 3 удаагийн хичээл заасан.
- 2019 оны 01-р сарын 10-ны өдөр чанарын албанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу их эмч Л.Энхтуяа, “Хүүхдийн шуугиантай амьсгал, ялган оношилгоо” сэдвээр 10 минутын товч мэдээллийг 17 эмч, сувилагч нарт мэдээлсэн. Үр дүнд нь эмч нарын мэдлэг ур чадвар, ялган оношилгооны чадвар сайжирсан.
- Төв салбарын 3 дугаар ээлжийн их эмч Д.Сувд, Б.Халиунаа нар 1 дүгээр сарын 31-ны өдөр “Зулбалт, түүнд үзүүлэх тусламж, оношилгоо, эмчилгээ” сэдвээр 16 эмчид сургалт орсон.



- Сонгинохайрхан салбарын 3 дугаар ээлжийн их эмч Г.Золбаяр, М.Энхтуяа нар 1 дүгээр сарын 31-ны өдөр “Цирроз печень өвчний оношилгоо, үзүүлэх тусламж, хүндрэл” сэдвээр салбартаа 28 их эмчид сургалт орсон.
- 1 дүгээр сард дуудлагын их эмч Ю.Уранзаяа “Имопек” эмийн хүүхдэд хэрэглэх заалт, гаж нөлөө, эсрэг заалт, “Залгиур салстын үрэвсэл, идээт үрэвсэл, нэвчдэст өвчин”-ий ялган оношилгоо, үзүүлэх эмчилгээний талаар 12 эмчид сургалт зохион байгуулсан. Ингэснээр эмч нарын амьсгалын дээд замын өвчний онош бичилт сайжирсан.

2019 оны эхний хагас жилд Засгийн газрын 11-11, 1800-1200 оператороос нийт 8 гомдол бүртгэгдсэн

Алдаа гаргасан ажилтан:/ давхардсан тоогоор/

- Их эмч-8  
Алдаа, зөрчлийн нэр, чиглэл:
- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой алдаа, стандарт удирдамж хангаагүй-4
- Хариуцлага, сахилга, ёс зүйтэй холбоотой-3
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний дагуу үйлчилсэн буюу үндэслэлгүй-1
- Дотоод хяналт, шалгалт үнэлгээгээр илэрсэн алдаа зөрчил 34 удаагийн 92 алдаа бүртгэгдсэн.

-2019 оны 03 дугаар сарын 01-нд Эрүүл мэндийн газраас зохион байгуулагдсан “Төсөл бичих аргачлал болон эрдэм шинжилгээний ажлыг хэрхэн хийх” талаарх сургалтад 1 сувилагч хамрагдсан. Энэ сургалтад хамрагдсанаар сувилагч, тусгай мэргэжилтний судалгааны ажил хийхэд болон төсөл боловсруулж сурахад мэдлэг олгосон тустай ажил болсон. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр:

Шахмал хуурай эмийг зөв стандартын дагуу хадгалах эмийн сав шинээр оёсон.

- Нийт тоо – 52 нийт үнийн дүн – 260 000₮



- Амилуулах тусламжийн сургалтын иж бүрдэлд ампултай эм тарианы жижиг цүнхийг шинээр хийж байршуулсан. Нийт үнийн дүн – 25200₮



Дуудлагад авч явдаг амбуны хайрцагт орчны бохирдлоос хамгаалж гадна уутыг шинээр хийсэн. Дуслын болон багажийн уут: Нэг бүрийн үнэ 2000\*20 ш=40.000₮



Хүүхдийн өлгийний уут: Нэг бүрийн үнэ 5000\*28 ш=140 000₮

Чигний уут: Угааж цэвэрлэхэд хялбар, чанартай бат бөх материалаар 31 ширхэг шинээр хийсэн. Нийт үнийн дүн – 186 000₮



хуучин




шинэ

2019 оны эхний улирлын хүүхдийн эндэгдлийн хэлэлцүүлгийг 04 дүгээр сарын 12-ы өдөр зохион байгуулсан.

- Нийт 25 эндэгдлийг 22 эмнэл зүйн тохиолдол болгон, тухайн хүүхдийн эндэгдэлд очсон дуудлагын эмх нарыг хэлэлцүүлэгт оролцуулсан. Мөн Сонгинохайрхан, болон Төв салбарын 1 ба 2 дугаар ээлжийн хүүхдийн оператор эмч нар оролцсон, нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлэг хийгдсэн.
  - Оролцсон эмч нар эмнэлзүйн тохиолдол тус бүр дээр хэлэлцэн ярилцсан. Үүнд:
    - Зовиур, асуумж, өвчний түүх авалт, нас барсан шалтгаан
    - Үзлэгт нас барсан байдлыг тодорхойлсон байдал
    - Нас барсныг тодорхойлсон, шийдвэрлэсэн байдал
    - Дуудлагын хуудас бичилт
    - Тус дуудлагын хуудсанд илэрсэн алдаануудыг өөрсдөөр нь хянуулж
    - Тухайн хүүхэд нас барсан эрсдлийг гаргаж тайлбарлах
    - Эрсдлийг бууруулах талаар ямар ажлуудыг хийх вэ зэрэг байдлаар хэлэлцүүлэг явагдсан.
  - Эндэгдэл тохиолдлын дүгнэлтийг үндэслэн магадлан хэлэлцэж, нотолгоонд суурилсан аргачлал зөвлөмж боловсруулан гаргасан. Гаргасан зөвлөмжийг нийт эмч нарт танилцуулан судлуулсан.
- Чанарын албаны дарга Д.Мөнхцэцэг, менежер З.Энхцэцэг, М.Цэрэнчимэд нар 04 дүгээр сарын 09-нд Баянгол эрүүл мэндийн төвд зохион байгуулагдсан “Гомдол, нас баралтын шалтгаанд эрсдлийн үнэлгээ хийх” дадлага, сургалтад хамрагдан суусан.

Эхийн эндэгдлийн эмнэлзүйн хэлэлцүүлэгт 02 дугаар 21-нд чанарын менежер З.Энхцэцэг, Б.Цэрэнчимэд нар Улсын гуравдугаар төв эмнэлэг дээр материал бэлдэж, оролцсон.



2018 оны 12 дугаар сарын 03-ны ЭМС-ын А/489 тоот тушаал “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн эмнэлзүйн заавар батлах тухай” судалж, үйл ажиллагаанд хэрэгжүүлэн, зарим төлөвлөгөө удирдамж боловсруулан ажилласан. Эрсдлийн удирдлагын багийг байгууллагын даргын 2012 оны 128 тоот тушаалаар орон

тооны бус 16 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, эрсдлийн удирдлагын багийн ажиллах журмыг баталж, төлөвлөгөө гарган ажилласан.

5 төрлийн эрсдлийн шалгуур хуудсыг боловсруулж, салбар төвүүдэд эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийн ангиллаар 75%-иас доош хувьтай салбар ээлжүүдэд дотоод хяналтыг тогтмол хийсэн.

Эмчилгээ, оношилгоо, тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэлд дуудлагын хуудас бичилтэд үнэлгээг хийсэн. Эхний хагас жилд нийт 10 удаа хяналт хийж, 192 алдаа зөрчил илрүүлсэн. Тогтмол хяналт хийсний үр дүнд 606-аас 124 болтлоо буурсан байна.

- Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаатай холбоотой эрсдлийг үнэлэх шалгуур хуудсыг шинэчлэн боловсруулж 116 эмч, эмнэлгийн ажилтнуудад үнэлгээ 2 удаа хийхэд 58.7%-92.1% болтол үнэлгээний хувь сайжирсан үр дүн гарсан.

Эм зүй, эм био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалтай холбоотой эрсдлийг үнэлэхэд

- 102 эмчийн алдаа зөрчлийг илрүүлж, зөрчлийг 100% арилгаж ажилласан.
- Тоног төхөөрөмжтэй холбоотой 5 эрсдлийн үнэлгээний хуудас боловсруулж, тоног төхөөрөмжийн ажиллагаатай холбоотой 20%-ийн зөрчил илрүүлж, засаж арилгасан.
- Хүүхдийн тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдлийг үнэлэх шалгуур хуудас шинээр боловсруулж, сар бүр үнэлгээ хийж 25%-д зөрчил илрүүлж, алдаа зөрчлөө бууруулж ажилласан.

Гадаад орчинтой холбоотой эрсдэлд дуудлагын автомашины замын хөдөлгөөнд оролцсон байдалд 9%-ийн эрсдэл гаргаж ажилласан. Иймд эрсдлийн бууруулах зорилгоор жолооны дүрмийн мэдлэгийг үнэлэх шалгалтыг авч дүгнэсэн.

- Эмнэлгээс шалтгаалах халдвар гараагүй болно.  
Эрсдлийн удирдлагын багийг байгууллагын даргын 2012 оны 128 тоот тушаалаар орон
- Төв, Хан-Уул салбар, Сонгинохайрхан салбар, Баянзүрх салбаруудын эмийн санд эм, тариа (дархлаажуулалтын үед вакцин хийдэг байсан) хадгалдаг байсан



хуучин хөргөгчийг тус бүр 450,000 төгрөгийн 4 ширхэг хөргөгчөөр сольж шинэчилсэн.

- Гепатитийн В вирусийн эсрэг вакцины гурав дахь тунд байгууллагынхаа 60 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж дархлаажуулсан. Үр дүнд гепатит В вирусийн халдвар авах эрсдэлгүй болсон.
- 05 дугаар сарын 29-ны өдөр тус төв нь байгууллагын эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын дунд “Дархлаажуулалтын өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Өдөрлөгөөр аньс, нэрс, чацаргана, “С” витамин, үрлэн аминдэмийг эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилчин албан хаагч нарт тараасан. Мөн дараах шинжилгээнүүдэд хамруулж, зөвлөгөө өгсөн.
- Элэгний В, С вирусийн шинжилгээг 64 хүнд
- Ясны сийрэгжилтийг тодорхойлох шинжилгээ 75 хүнд
- ДЭМБ-ын зөвлөмж болгосон томуугийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар 350 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчин албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулсан. Жил бүрийн дөрөвдүгээр улиралд нэгдсэн журмаар томуугийн дарлаажуулалтад хамрагдаж байна.

“Гарын эрүүл ахуй” сэдэвт өдөрлөгийг ХУС -ийн нийт 21 эмч, сувилагч, тогооч, үйлчилгээний ажилчдын дунд зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр нийт ажилчдаас гар угаах стандартаар шалгалт авч, Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх, эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх, 186,187-р тоот тушаалуудын дагуу сургалтыг явуулсан. Гарын эрүүл ахуйн талаарх үзүүлэн гарын авлага боловсруулан нийт ажилчдад тарааж, “Гар угаах болон халдваргүйжүүлэлтийн стандарт”-аар кино хичээл үзсэн. Үр дүнд нь гараа тогтмол угаах хэвших сэдэл эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эерэг хандлага үүссэн.

- Чингэлтэй дүүргийн 8 дугаар хороотой хамтран “Сувилагчийн нэг өдөр” өдөрлөгийг хорооны иргэний танхимд зохион байгуулсан. Өдөрлөгт 8-р хорооны 9 хэсгийн зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, ганц бие өндөр настангуудыг хамруулсан. Тус өдөрлөгөөр халдварт өвчнөөс хэрхэн сэргийлэх гараа хэрхэн зөв угаах тухай хичээл болон тараах материалуудыг иргэдэд тараасан.



- Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн 56 сурагчдад “Гарын эрүүл ахуй түүний ач холбогдлын тухай” сэдэвт хичээлийг Баянзүрх салбарын 12 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамтарч хийсэн. Үүний үр дүнд хүүхдүүд гараа угаахын ач холбогдол болон бохир гараар дамждаг халдварт өвчнүүдийн тухай мэдлэгтэй болсон.

#### 4.1.16.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил зохион байгуулах

2019 онд тус төвийн нийт 397 ажилчдад 88 удаагийн 196 цагийн мэргэжлийн сургалт, 64 удаагийн 160 цагийн англи хэлний сургалт, 12 удаагийн 96 цагийн ХӨЦМ-ийн сургалтуудыг тус тус зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласан.

Эмч, сувилагч нарт дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- Хууль эрх зүй, ёс зүйн сургалт 6 удаагийн 11.5 цагийн сургалт зохион байгуулсан.Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага сэдэвт сургалт 5 удаа 9.5 цагийн сургалт давхардсан тоогоор 187 захиргааны ажилтан, эмч, сувилагч, дагалдан эмч, жолооч нар хамрагдсан. / Герман улсын эмч доктор Поп. АУ доктор Д.Оюунбилэг, С.Наранчимэг/

- Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн 2 удаагийн 2 цагийн сургалт 125 захиргааны ажилтан, эмч, сувилагч, дагалдан эмч, жолооч нар хамрагдсан. /Хуульч, өмгөөлөгч Э.Ганбат/

- Зүрх судасны өвчин, харвалтаар 5 удаагийн 5 цагийн сургалт 131 эмч, сувилагч, дагалдан эмч нар хамрагдсан./ШУГТЭ Харвалтын тасгийн их эмч П.Бурмаа, ЦТЭ Мэдрэлийн тасгийн ахлах эмч Н.Золжаргал, ЦТЭ ЗС тасгийн эрхлэгч С.Батболд/

- Халдварт өвчнүүдээр 7 удаагийн 7 цагийн сургалт 128 эмч, сувилагч, дагалдан эмч нар хамрагдсан. /ХӨСҮТ-н эмч С.Ундармаа, Гэрэлмаа, А.Мөнхзул, Э.Одгэрэл/

- Осол гэмтэл, ходлоготой холбоотой 7 удаагийн 7 цагийн сургалт 117 эмч, сувилагч, дагалдан эмч нар хамрагдсан. /ХЯТҮТ-н эмч Б.Сэргэлэн, С.Юндэн, Б.Тэгшжаргал, Т.Мөнхболд нар/

- Тус төвийн гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн үед хэрхэн ажиллах, амилуулах тусламжийн эрэмбэлэн ангилалт, байгууллагын гамшгийн төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалт сэдвээр дэд захирал С.Ариунболд, сургалтын ажилтан Б.Тэгшжаргал нар 7 удаагийн тус бүр 4 цагийн сургалт

- ХӨЦМ сэдэвт 96 цагийн 12 удаагийн сургалтыг ХУЭМТөвийн хүүхдийн мэргэжилтэн, ХӨЦМ-н үндэсний сургагч багш Б.Онон тус төвд шинээр ажилд орсон 57 эмч, дагалдан эмч нар хамрагдсан.

➤ Бусад:


- Англи хэлний нийт 160 цагийн 64 удаагийн сургалтыг “Unigram” сургалтын төвтэй гэрээ байгуулж 50 эмч, сувилагч, захиргааны ажилчид зохион байгуулхаас 14 удаагийн 28 цагийн сургалт зохион байгуулсан.



Дээрх сургалтуудын үр дүнд эмч, сувилагч, дагалдан эмч нарын мэдлэг, ур чадвар дээшлэн, тус төвд дуудлага өгсөн иргэд үйлчлүүлэгчдэд газар дээр үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан.

Ингэснээр өвчнийг эрт, зөв оношлох, эмнэлзүй төстэй өвчнүүдийг зөв ялган оношлох, эмнэлэг хооронд тээвэрлэлтийн хүндрэлүүд буурсан.

### Ажлын байрны сургалтын цагийг өмнөх онтой харьцуулахад:



Жолооч нарт 23 удаагийн 27 цагийн сургалт зохион байгуулсан. Үүнд:

Автомашиньг хоёр хувингийн аргаар ариутгаж, халдваргүйжүүлэх үзүүлэх сургалтыг 2 дугаар сарын 26-28-ний өдрүүдэд нийт 84 жолоочийн 3 цагийн сургалтанд хамруулсан. Сургалтыг Герман улсын Эссэн хотын гал унтраах ангитай туршлага солилцон ажилласан шалгах механик В.Түвшиндэлгэр, 2-р ээлжийн техникийн ажилтан Ц.Эрдэнэбадрах нар нэг автомашиныг 50 минутын хугацаанд бүрэн ариутгаж, үзүүлэх сургалтыг амжилттай зохион байгууллаа.



Мэргэшсэн жолоочийн сургалтын системчилсэн сургалтанд 9 жолоочийг хамруулан Тээвэрлэлтийн гэрээ, Автотээврийн салбарын олон улсын холбогдох конвенц, гэрээ, хэлэлцээр болон үндэсний хууль, дүрэм, журам тээвэрлэлтийн болон техникийн стандартууд, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Харилцааны соёл, тээвэрлэлтийн ажил үйлчилгээний соёл чанарыг дээшлүүлэх, Замын хөдөлгөөний осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх,ослын үед авах арга хэмжээ, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх

- Амилуулах тусламж
- Автомашины ариутгал халдваргүйтгэл
- Автомашины тоног төхөөрөмжийн ашиглалт зэрэг нийт 12 цагийн сургалт зохион байгуулан үнэмлэх сертификат олгосон.

Уг сургалтад хамрагдсанаар жолооч нарын замын хөдөлгөөний нөхцөл байдлыг үнэлж, тохирох арга хэмжээг авах ур чадвар, эмнэлгийн тоног

төхөөрөмжийн ашиглалтын мэдлэг дээшилж, яаралтай дуудлагын нөхцөл байдлыг үнэлж эмч, сувилагчтай багаар ажиллах чадвар дээшилсэн.

ХБНГУ-ын Эссен хотын гал унтраах ангийн парамедикийн сургагч багш Ёорг Спорс жолооч нарт эмнэлгийн анхан шатны суурь тусламж, шархны цэгцлэлт, автомашины халдвар хамгаалал, хоёр хувингийн арга, чих хамар хоолойн яаралтай тусламж, багаар хэрхэн газар дээрх болон эмнэлэг хүртэл тусламж үзүүлэх вэ сэдэвт хоёр өдрийн сургалтанд он 10 жолооч, ашиглалтын инженер С.Оюунсүвдэн хамт идэвхитэй оролцсон. Уг сургалтад хамрагдсанаар жолооч нар маань сургагч багш болж эзэмшсэн мэдлэгээ өдөр тутмын тусламж үйлчилгээндээ ашиглах болсон.

Гамшгийн үеийн бэлэн байдлын тухай, гамшгийн үед хэрхэн ажиллах, амилуулах тусламжийн эрэмбэлэн ангилалт, байгууллагын гамшгийн төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалт зэрэг мэдээллийг олгохоор нийт 73 жолооч, ажилчдыг 4 цагийн сургалтанд хамрууллаа. Мөн салбаруудад гамшгийн үеэр цуглах цэгийн тэмдэглэгээ 5 ширхгийг хэвлүүлж салбар бүрт байршуулсан.

Дээрх сургалтуудыг зохион байгуулснаар жолооч нарын замын хөдөлгөөний нөхцөл байдлыг үнэлж, тохирох арга хэмжээг авах ур чадвар эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалт, тоног төхөөрөмжийн аюулгүй, бэлэн байдал сайжирч, газар дээрх болон эмнэлэг хүртэлх багаар тусламж үзүүлэх мэдлэг чадвар дээшилсэн.

#### **Нийгмийн асуудал шийдвэрлэсэн байдал:**

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах, ажилчдын ажиллах урам зоригыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:


- 39029000 төгрөгний өвөл зуны хувцас олгосон
- 8600000 төгрөгний хөдөлмөрийн хэрэгсэл олгосон
- 350 ажилтанг улирал тутамд 239165300 төгрөгний цалингийн хувиар урамшуулсан
- 7 ажилтаныг 575000 төгрөгний дотоодын сургалтын зардлаар сургасан
- 456 ажилтанд хоол унааны 412518100 төгрөг зарцуулсан
- тэргүүлэх зэрэгтэй 6 эмчид 7243300 төгрөг
- ахлах зэрэгтэй 11 эмчид 8718800 төгрөг
- ахлах зэрэгтэй 10 сувилагчид 7438300 төгрөг
- 134 жолоочид мэргэшсэн жолоочийн 120404200 төгрөгний мэргэжлийн зэргийн нэмэгдэл
- 1 ажилтанд гадаадын сургалтын 1300000 төгрөг
- 9507900 төгрөгний байгууллагын сургалтанд ажилчдыг хамруулсан.

Байгууллагын дотоод журмын дагуу:

- 204 ахмадад 125560000 төгрөгний хүндэтгэл үзүүлсэн.
- эх үрсийн баяраар 438 хүүхдэд 16614000 төгрөгний гарын бэлэг өгсөн.
- 17 ажилтанд 3965700 төгрөгний цалинтай чөлөө өгсөн.
- 15 ажилтанд 14468600 төгрөгний тэтгэмж тусламж
- тэтгэвэрт гарч байгаа 1 ахмадад 1020000 төгрөгний тусламж

-1 ахмадад 165000 төгрөгний орон нутагт ирж очсон унааны зардал тус тус олгосон.

### Ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэсэн мөнгөн дүнг 2018 онтой харьцуулахад:



### Гадаад дотоодын ижил төст байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд

1. ХБНГУ-ын Эссэн хот, Монгол улсын Улаанбаатар хотын хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Эссэн хотын Аврах гал унтраах анги, Их сургуулийн нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын Нийслэлийн Түргэн тусламжийн төв 4 үндсэн чиглэлээр хамтран ажиллаж байна.

#### 2. Япон улс

АМДА олон улсын байгууллага:

Олныг хамарсан гамшиг ослын үед харилцан туслалцах Яаралтай тусламжийн чиглэлээр харилцан туршлага солилцох, Яаралтай тусламжийн сургагч багш бэлтгэх сургалтад хамруулах чиглэлээр:



#### 4. Энэтхэг улс

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн Хяналт шинжилгээ үнэлгээний албаны дарга А.Алтанзагас 2019 оны 02 дугаар сарын 27-оос 03 дугаар сарын 08-ны хооронд Энэтхэг улсын Chandigarh хотод зохиогдсон Олон Улсын эрүүл мэндийн менежментийн сургалт семинарт оролцсон. Уг сургалтад 22 орны 32 төлөөлөгч нар оролцсон бөгөөд олон улсын эрүүл мэндийн удирдлага, эрүүл мэндийн бодлого, бодлогын хэрэгжилт, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн талаар сургалт, дадлага хосолсон 10 хоногийн сертификаттай сургалтад оролцсон.



1. Эрүүл Мэндийн Яамнаас 2019 оныг “Инээмсэглэл – Эерэг хандлага” гэсэн уриатай жил болгон зарласантай холбогдуулан Холбооны Бүгд Найрамдах Германы улсын Эссэн хотын эмнэлгийн профессор Вальтер Попп тус төвийн эмч ажилчдад “Эрүүл мэндийн ажилтны ес зүй харьцаа хандлага” сэдвээр 1 цагийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар Германы эмч нарын болон эмнэлэгт баримтлах ёс зүйн дүрэм, хүний эрхийг хамгаалах дээдлэх талаар олон сайхан жишээ баримтуудыг дурдлаа.



## 2. ПРОФЕССОР ТАКИШИ САТО БАГШИЙН СУРГАЛТ

AMDA- The Association of medical doctors of Asia- Азийн эмч нарын нийгэмлэг нь анх 1984 онд Япон улсын Окаяма мужид анх байгуулагдсан бөгөөд одоо дэлхийн 30 гаран оронд салбар байгууллагатай. Тус байгууллага нь нийслэлийн түргэн тусламжийн төвтэй 3 чиглэлээр хамтран ажиллаад 6 жил болж байна. 2017 оноос Зүүн Азийн их сургуулийн Профессор Такиши Сато багш нийслэлийн түргэн тусламжийн эмч нарт 3 дах удаагийн сургалтаа амжилттай явууллаа. Монгол улсын эрүүл мэндийн салбарт болон Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн эмч нарт 3 жил дараалан сургалт зохион байгуулсанд талархаж тус төвийн захирал Ц.Пүрэвдаш Проф. Сато багшид талархлын гэрчилгээ гардуулав.

Энэ удаагийн сургалтаар:

- Амьсгалын зам чөлөөлөх, цагаан мөгөөрсөн хоолойг нээх мэс ажилбар
- Эмнэлзүйд суурилсан оношилгоо эмчилгээний чиглэлээр сургалт хийгдлээ



Мөн Проф.Сато багш, тус төвийн дэд захирал С.Ариунболд, сургалтын ажилтан Б.Тэгшжаргал нар сургалтыг зохион байгуулж Эрдэнэт хотын “ЭРДЭНЭТ МЕДИПАС” оношилгоо эмчилгээний төвд 2019 оны 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд эмнэлгийн их эмч нарт дараах сургалтыг зохион байгуулав.

- Гамшгийн үеийн тусламж арга аргачлал
- Үнхэлцгэнд хатгалт хийх
- Ясанд хатгалт хийх , шингэн сэлбэх

Амьсгалын зам чөлөөлөх, цагаан мөгөөрсөн хоолойг нээх мэс ажилбар сэдвээр нийт 57 эмч нарт сургалт хийгдэв



3. Нийслэлийн хэмжээнд зохиогдож буй Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтийн үеэр Нийслэлийн Түргэн тусламжийн төвтэй сүүлийн жилүүдэд хамтран ажиллаж байгаа Япон улсын Окайяма хотод байрладаг ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн гамшгийн үед харилцан туслалцах үйл ажиллагаа явуулдаг “AMDA” ТББ-ийн гүйцэтгэх захирал Намба Сан хүрэлцэн ирж тус төвийн штабын бие бүрэлдэхүүний явуулж буй гамшгийн үеийн үйл ажиллагаатай танилцаж, хэрхэн ажиллах, цаашид анхаарал зүйлсийн талаар зөвлөгөө өгч санал солилцов.



4. 2019 он 05 дугаар сарын 12-ны өдөр НЭМГазраас зохион байгуулсан “Гадаад харилцаа-дэлхийн даяарчлал” сургалтад хамрагдсан.



5. Нийслэлийн түргэн тусламжийн төв болон ХБНГУ-ын Эссэн хот 2010 оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй Mongolian Emergency Service Hospital Hygiene Project (MeshHp) төслийн удирдагч ХБНГУ-ын Эссэн хотын эмнэлгийн дарга Проф. Walter Popp 2019 оны 05 дугаар сарын 09-18-ны хооронд Монгол Улсад айлчлан ирж цаашид хийгдэх төслийн талаар хэлэлцэв. Төслийн хүрээнд НТТТ, амаржих газрууд, нэгдсэн дүүргийн эмнэлгүүд, II эмнэлэг хамтран ажилладаг бөгөөд энэ жилийн төсөлд хөдөө орон нутаг руу ажлуудын талаар болон, сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаан дээр ажиллах талаар ярилцлаа.



6. 2019.09.12-ний өдөр АМДА Олон улсын байгууллагын гүйцэтгэх захирал Тае Намбаг тус төвийн захирал Ц.Пүрэвдаш хүлээн авч уулзан 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган харилцан ярилцлаа.



7. 2019.09.10-2019.09.12-ний өдрүүдэд ХБНГУ-ын Эссэн хотын гал унтраах ангийн парамедикийн сургагч багш Ноён Ёорг Шпорс тус төвийн жолооч нарт эмнэлгийн анхан шатны суурь тусламж, шархны цэгцлэлт, автомашины халдвар хамгаалал, 2 хувингийн арга, чих хамар хоолойн яаралтай тусламж, багаар хэрхэн газар дээрх болон эмнэлэг хүртлэх эмнэлгийн тусламж үзүүлэх сэдвүүдээр 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Үүний үр дүнд жолооч нарын ур чадвар дээшилсэн.





8. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Эссэн хотын орлогч дарга Петр Рензелийг хүлээн авч уулзлаа. Уулзалтад Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар, НЗДТГ-ын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Чинзориг, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш, Төслийн эмнэлгийн эрүүл ахуйн холбооны дэд ерөнхийлөгч, Хикомед компанийн халдварын хяналт сэргийлэлтийн дарга Волтер Попп, Эссэн хотын Яаралтай түргэн тусламжийн халдварт өвчний тасгийн дарга Иорг Шпросс, Хукомед компанийн микробиологийн лабораторийн эрхлэгч Михайл Россбург болон холбогдох албаныхан оролцов.

Эмнэлгийн эрүүл ахуй, халдварын сэргийлэлт ба хяналтыг сайжруулах зорилготой “Эмнэлгийн яаралтай түргэн тусламж, эмнэлгийн эрүүл ахуй” /Mongolian Emergency Service Hospital Hygiene Project – MeshHp төсөл нь 2010 оноос эхэлсэн бөгөөд ХБНГУ-аас Монгол улсад олон улсын стандартад нийцэх олон талт үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байгаа билээ. Уулзалтаар хоёр тал хамтын ажиллагааг цаашид үргэлжлүүлэх, харилцан туршлага солилцон ажиллахаар боллоо.




9. 2019.09.10-ний өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайд Ноён Ёрн Розенберг, Дэд тэргүүн бөгөөд Элчин зөвлөх Др.Михаэль Фернау нар Төслийн удирдагч Ноён Валтер Попп, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш нарыг хүлээн авч уулзлаа. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон ХБНГУ-ын Эссэн хотууд 2010 онд хэлэлцээр байгуулж, хамтран ажиллаж эхэлсэн. Уг хэлэлцээрийн хүрээнд Монголын эрүүл мэндийн байгууллагаас 130 гаруй эмч, сувилагч Герман улсыг зорьж ажлын туршлага солилцсон. Мөн жилдээ 4-5 удаа Герман эмч, сувилагчид Монголд ирж зөвлөгөө өгч хамтран ажиллаж байгааг уулзалтаар талууд онцлон ярилцлаа. Уулзалтаар хоёр тал хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх, харилцан туршлага солилцож ажиллахаар боллоо.



10. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш, Олон улсын яаралтай тусламжийн диспетчерийн академийн ерөнхийлөгч "The International Academies of Emergency Dispatch-IAED " Ноён Gary R.Payne хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар цаашид түргэн тусламжийн дуудлагын тогтолцооны талаар болон хамтын ажиллагааг эхлүүлэх талаар хэлэлцсэн.



11. 2019.09.12-ний өдөр АМДА Олон улсын байгууллагын гүйцэтгэх захирал Тае Намбаг тус төвийн захирал Ц.Пүрэвдаш хүлээн авч уулзан 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган харилцан ярилцлаа.

12. 2019.09.10-2019.09.12-ний өдрүүдэд ХБНГУ-ын Эссэн хотын гал унтраах ангийн парамедикийн сургагч багш Ноён Ёорг Шпорс тус төвийн жолооч нарт эмнэлгийн анхан шатны суурь тусламж, шархны цэгцлэлт, автомашины халдвар хамгаалал, 2 хувингийн арга, чих хамар хоолойн яаралтай тусламж, багаар хэрхэн газар дээрх болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламж үзүүлэх сэдвүүдээр 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Үүний үр дүнд жолооч нарын ур чадвар дээшилсэн.

13. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Эссэн хотын орлогч дарга Петр Рензелийг хүлээн авч уулзлаа. Уулзалтад Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар, НЗДТГ-ын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Чинзориг, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш, Төслийн эмнэлгийн эрүүл ахуйн холбооны дэд ерөнхийлөгч, Хикомед компанийн халдварын хяналт сэргийлэлтийн дарга Волтер Попп, Эссэн хотын Яаралтай түргэн тусламжийн халдварт өвчний тасгийн дарга Иорг Шпросс, Хукомед компанийн микробиологийн лабораторийн эрхлэгч Михайл Россбург болон холбогдох албаныхан оролцов.



14. 2019.09.10-ний өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайд Ноён Ёорн Розенберг, Дэд тэргүүн бөгөөд Элчин зөвлөх Др.Михаэль Фернау нар Төслийн удирдагч Ноён Валтер Попп, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш нарыг хүлээн авч уулзлаа. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон ХБНГУ-ын Эссэн хотууд 2010 онд хэлэлцээр байгуулж, хамтран ажиллаж эхэлсэн. Уг хэлэлцээрийн хүрээнд Монголын эрүүл мэндийн байгууллагаас 130 гаруй эмч, сувилагч Герман улсыг зорьж ажлын туршлага солилцсон. Мөн жилдээ 4-5 удаа Герман эмч, сувилагчид



Монголд ирж зөвлөгөө өгч хамтран ажиллаж байгааг уулзалтаар талууд онцлон ярилцлаа. Уулзалтаар хоёр тал хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх, харилцан туршлага солилцож ажиллахаар боллоо.

15. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш, Олон улсын яаралтай тусламжийн диспетчерийн академийн ерөнхийлөгч "The International Academies of Emergency Dispatch-IAED" Ноён Gary R. Payne хүлээн авч уулзлаа. Уулзалтаар цаашид түргэн тусламжийн дуудлагын тогтолцооны талаар болон хамтын ажиллагааг эхлүүлэх талаар хэлэлцсэн.



16. Тус төвийн Дэд захирал С.Ариунболд 2019.12.05-ны өдөр БНФУ-ын "Софэма" группийн нисдэг тэрэг хариуцсан мэргэжилтэн ноён Марк Монжуг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагаанд нисдэг тэрэг ашиглах боломж, түргэн тусламжийн өнөөгийн нөхцөл байдлын талаар харилцан ярилцлаа.

17. Англи хэлний сургалт: Байгууллагын ажилчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэх, олон улсын сургалт семинарт эмч ажилчдыг хамруулах, гадаад иргэдийн дуудлагад түргэн тусламжийн баг чөлөөтэй ойлголцдог болгох зорилгоор 2019.11.11-ний өдрөөс "Unigram" англи хэлний төвтэй хамтран нийт 160 цагийн 64 удаагийн 3 сарын хугацаатай англи хэлний сургалтыг Хэл шинжлэлийн ухааны доктор профессор Ж.Оюунцэцэг багш нийт 48 эмч, сувилагч, захиргааны ажилчдад амжилттай зохион байгуулж байна. Байгууллагын эмч нараас 2019.05 сард англи хэлний мэдлэгийн түвшинг тогтоох шалгалт авч, судалгаа гаргаж англи хэлний сургалтад суух шаардлагатай эмч нарыг сонгон шалгаруулсан. Сургалтын эхэнд англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авахад дундаж 12.5 хувьтай буюу 77.3% нь анхан шатны түвшингээс доогуур үнэлэгдсэн. 2019.12.02-ний өдөр явцын шалгалт авахад суралцагчдын түвшин 64.5 хувь болж дээшилсэн. Сургалтын үр дүнд эмч ажилчдын англи хэлний мэдлэгийн түвшин дээшилж байна.



#### 1.4.5. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан олон талт арга хэмжээнүүд зохион байгуулах

- 4-н төрөлтийн тэмцээнийг ширээний теннис, шатар, гар бөмбөг, сагсан бөмбөгийн төрлөөр зохион байгуулсан. БЗСалбар, ХУСалбар, СХСалбар, Төв салбаруудын баг тамирчид 4-н төрөлтийн тэмцээнд тэргүүн болон дэд байруудыг эзэлж амжилттай оролцсон. Гарсан зардал-1,135,800 төгрөг.




- Тус байгууллагын 10 албан хаагч, ажилтан илүүдэл жингээ хасаж, биеийн жингээ хэвийн хэмжээнд хүргэсэн. Бэлтгэгч Г.Оюун нь 2019 оны 01 дүгээр

сараас эхлэн илүүдэл жингээ аажмаар бууруулж, 95 кг-аас 84 кг хүртэл нийт 11 кг жин хассан эерэг үзүүлэлттэй байна.

- 05-р сард сувилахуйн алба гар бөмбөгийн холимог багийн тэмцээн зохион байгуулж сувилахуйн алба тэргүүн байранд, дэд байранд 1-р ээлжийн их эмч, жолооч нарын холимог баг, гуравдугаар байранд 3-р ээлжийн эмч нарын багууд тус тус шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагнал хүртсэн.



- Байгууллагын хэмжээнд Дартсын тэмцээн зохион байгуулж, 24 эмч, ажилчид албан хаагч нар оролцсон бөгөөд 1, 2, 3 дугаар байр эзлүүлсэн. Эмэгтэй төрөлд-сэлбэгийн нярав Э.Оргил, эрэгтэй төрөлд жолооч



- Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны нэрэмжит сагсан бөмбөг, гар бөмбөг, дартсын төрлүүдээр бооцоот тэмцээн зохион байгуулагдаж, дартсын эмэгтэй, эрэгтэй төрөлд нягтлан бодогч А.Жанцанхорлоо, жолооч И.Ням-Эрдэнэ нар 4-р байранд шалгарсан.

2019 оны 03 дугаар сард Нийслэлийн харьяа байгууллагуудын дунд зохион байгуулагдсан сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцсон.



- Баянзүрх, Сонгино хайрхан салбарууд болон автобазад чийрэгжүүлэлтийн зориулалтын тоног төхөөрөмжтэй биеийн тамирын танхимуудыг байгуулж 4 дэх жилдээ ажиллаж байна. Зориулалтын тоног төхөөрөмжтэй болсноор биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл бүрдэж, бие бялдраа хөгжүүлэн чийрэгжүүлсэн эмч, ажилчдын тоо өсөж, халдварт бус өвчний өвчлөл буурсан.

“УЛААНБААТАР-МАРАФОН-2019” Олон Улсын гүйлтийн тэмцээн:

2019 оны 05 дугаар сарын 18-ний өдөр Нийслэлд зохиогдсон Автомашингүй өдөр, Улаанбаатарын Марафон-2019 арга хэмжээ тус төвөөс эмч, сувилагч, жолооч нарын 5 баг эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.

Тус өдөрлөгийн хүрээнд Сүхбаатарын талбайд их эмч Бат-Ирээдүй, Төгөлдөр, Энхжин жолооч н.Мянганбуу нар иргэдэд анхны тусламжийн мэдлэг мэдээлэл, гардан үйлдлийн сургалтыг заасан. 200 ш гарын авлага, материалуудыг сургалтад хамрагдсан хүмүүст тарааж өгөв.



Нийт 33 гүйлтэд оролцсон иргэнд анхан шатны тусламж үзүүлж, ГССҮТ-д хүргэж дараагийн шатны тусламж үзүүлсэн. 12 тамирчин зөөлөн эдийн гэмтэл, 5 тамирчны булчин зангирч, 3 хүний даралт ихсэж, анхны тусламж авсан ба ард иргэдийн дунд цусны даралт ихсэлт болон зүрх судасны өвчтэй үйлчлүүлэгчид тус тус үзүүлэн яаралтай тусламж авсан.



#### 2.4.23. Гамшгийн эрсдлийн үнэлгээ болон төлөвлөгөөнд тодотгол хийх

Нийслэлийн Засаг даргын А/243-“Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцох тухай” захирамжийн дагуу 2019 оны 03 сард 15 зүйлтэй төлөвлөгөө гарган оролцсон. Төвийн захирлын 2019 оны 03 дугаар сарын 05-ны А/14 тоот тушаалын дагуу “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчилж байгууллагын гамшгийн штабыг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн штабын дарга С. Ариунболд болон сургалтын албаны ажилтан Б.Тэгшжаргал нар Нийслэлийн түргэн тусламжийн төвийн эмч, сувилагч, жолооч, авто баазын ажилчдад гамшиг болон түүнтэй холбогдох хууль дүрэм, мэдээ мэдээлэл, гамшгийн үеийн эрэмбэлэн ангилалт, газар дээрх тусламж үйлчилгээ, эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай хичээл, сургалтыг 5 удаа зохион байгуулан ажилласан.



Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн мэргэжлийн ангийн хүн, хүч хариуцсан ажилтан С.Акерке болон мэргэжлийн ангийн гишүүдийн оролцоотой Гамшгийн үед ажиллах эмч, ажилчдын судалгаа болон нөөцөд байх шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, тоног төхөөрөмж, хоол хүнс, шатахуун тос, тослох материалын судалгааг тус тус гаргаж ажиллав. Тухайн сургалтын үед түргэн тусламжийн төвийн эмч, сувилагч, жолооч, эм зүйч, халдвар судлаач, аж ахуйн алба, эмчилгээ чанарын алба, статистик дүн бүртгэл, авто бааз, санхүүгийн алба гэсэн өргөн бүрэлдэхүүнээр оролцов.



Гамшгийн штабын нийт бүрэлдэхүүнийг иж бүрэн хувцсаар хангасан. Сүхбаатарын талбайд болсон хүндэт парад жагсаалд байгууллагаа төлөөлөн оролцсон 12 дуудлагын их эмч, жолооч нар байгууллагын ажилчдын дүрэмт хувцсаар жигдэрч оролцсон. 2019 оны 03 дугаар сарын 21-нд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам батлах” тухай 339 дүгээр тогтоол, 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам батлах” тухай 340 дүгээр тогтоол, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирлын 2019 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн А/14 дүгээр тушаалын дагуу “Гамшгаас хамгаалах дадлага, сургалт”-ыг 2019 оны 03 сарын 21-ны 16.00 дуут дохиогоор “Суу, нуугд, хүлээ” алхмын дагуу гүйцэтгэж дарааллын дагуу аюулгүй цэгт цугларсан. Дуудлагад үйлчилж буй 16 эмнэлгийн тоноглогдсон автомашин 1 минутын турш дуут дохиогоо дуугаргасан. Штабын дарга дэд захирал С.Ариунболд зохион байгуулан, штабын дэд дарга М.Цэрэнчимэд бүртгэл хөтлөн ажилласан. Ажиллаж байсан нийт 56 ажилтан, ажиллагсад 100 хувийн ирцтэйгээр оролцов. Мөн гамшгийн үед ажиллах мэргэжлийн ангийн талаар 10 минутын сургалт хийсэн.



Нийслэлийн хэмжээнд зохиогдсон энэхүү сургалтын үеэр Түргэн тусламжийн төвийн тоноглогдсон автомашин, мэргэшсэн жолооч, их эмчийн хамт Гамшгийн штабын төв байрны гадаа бэлэн байдал хангаж ажиллахаас гадна дуудлагын 10 иж бүрэн тоноглолтой автомашин бэлэн байлгаж ажилласан.



Сонгинохайрхан дүүргийн Баянголын амралтад болсон Марш тактикийн уралдаанд тус төвийн 3 их эмч, 3 сувилагч, 3 жолооч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр аюул ослоос урьдчилан сэргийлж, тэмцээнд оролцож, Нийслэлийн захиргааны байгууллагуудын бие төлөөлөгчдөд анхны тусламжийн талаар их эмч Б.Батзул, Т.Машбат, Н.Баттуул нар хичээл заасан.



Тус байгууллагын мэргэжлийн ангийн гишүүд Гамшиг-2019 сургалтын хүрээнд “Хүй долоон худаг”-т зохиогдож байгаа Улсын I, II III дугаар эмнэлгүүд, ГССҮ төвүүдийн хээрийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалж ажиллаа.

Нийслэлийн хэмжээнд зохиогдож буй Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтийн үеэр Нийслэлийн Түргэн тусламжийн төвтэй сүүлийн жилүүдэд хамтран ажиллаж байгаа Япон улсын Окайяма хотод байрладаг ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн гамшгийн үед харилцан туслалцах үйл ажиллагаа явуулдаг “AMDA” ТББ-ийн гүйцэтгэх захирал Намба Сан хүрэлцэн ирж тус төвийн штабын бие бүрэлдэхүүний явуулж буй гамшгийн үеийн үйл ажиллагаатай танилцаж, хэрхэн ажиллах, цаашид анхаарал зүйлсийн талаар зөвлөгөө өгч санал солилцов.

### **3.3. Хот тохижилт ногоон байгууламжийн талаар**

Зүлэг мод тарих бэлтгэл ажлыг хангаж хөрс, шороог өөрсдийн хүчээр бэлдэж байгууллагын тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд жимсний 68 суулгац, бутыг суулган арчлалд, хамгаалалт тал дээр анхаарч ажиллаж байна.



### **9.1.2. ХОЁРДУГААР БҮЛЭГ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН**

Монгол Улсын Засгийн газрын тогтоол-2

- 23-“2019 оныг иргэнд төвтэй төрийн үйлчилгээний жил болгох тухай”
- 59- “2019 оныг эх орны худалдан авалтын жил болгох тухай”

Нийслэлийн Засаг даргын албан даалгавар-2

- 03- “Хот нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- 04 –“Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”

Нийслэлийн Засаг даргын захирамж-1

- А/881-“ Журам батлах тухай” урамшуулал олгох

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын тушаал-1

- А/104 –“Ажлын хэсэг байгуулах тухай”

НИТХТ-ийн тогтоол -1

- 184- “Ой тэмдэглэхийг зөвшөөрөх тухай”

Монгол Улсын Шадар сайдын тушаал-1

- 120- “Заавар батлах тухай” /гамшгаас хамгаалах/

Нийслэлийн Засаг даргын захирамж-1

- А/440 –“Улаанбаатар Марафон 2019 ОУ-ын гүйлтийг зохион байгуулах тухай”

УБ хотын Ерөнхий менежерийн тушаал-3

- А/99- “Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай”
- А/01-“2019 оныг Иргэдийн оролцоотой хөгжлийн жил болгон зарлах тухай”
- А/243-“Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцох тухай”

Эрүүл мэндийн сайдын албан даалгавар-3

- 08-“Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед авах зарим арга хэмжээний тухай”
- 09-“Улаан бурхан өвчний болзошгүй дэгдэлтээс сэргийлэх зарим арга хэмжээний тухай”
- 13- “Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах”

Эрүүл мэндийн сайдын тушаал- 9

- А/07-“Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах тухай”
- А/09-“Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх тухай”
- А/14-“Эмнэлгийн түргэн тусламжийн автомашиныг хуваарилан үндсэн хөрөнгөд бүртгэх”



- А/19-“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт зохион байгуулах тухай”  
- А/74-“Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой зарим халдварыг илрүүлэх тандалтын заавар батлах тухай”  
- А/179 –“Иргэн төвтэй төрийн үйлчилгээ, инээмсэглэл эерэг хандлагын жил болгох”

- А/228 –“Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай”  
- А/486- “ТТТӨ үеийн Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, зохион байгуулах арга хэмжээ авах тухай”

- А/503- “Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай”

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын албан даалгавар –1

- 04 дүгээр “Төр болон хувийн хэвшлийн байгууллагуудад эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллах”

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал-26

- А/02- “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”

- А/15- “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”

- А/14- “Цалин хөлсийг шинэчлэн тогт..оох тухай”

- А/19- “Сургалт зохион байгуулах тухай”

- А/24- “2018 оны үр дүнгийн гэрээ болон түншлэлийн гэрээг дүгнэсэн тухай”

- А/27- “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцох тухай”

- А/25- “Харьяа эрүүл мэндийн байгууллагын 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлсэн тухай”

-А/33- “Амралтын хуваарь батлах тухай”

- А/37-“Статистик эмч нарыг уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах тухай”

- А/48-“Олон улсын сувилагчийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай”

- А/51-“Хачгаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”

- А/50 –“Хүүхдийн тусламж үйлчилгээнд зохицуулалт хийх тухай”

- А/55 –“Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих жил болгох тухай”

- А/60 –“Нэгдсэн жагсаал оролцох тухай”

- А/59 –“Эмнэлгийн тусламж үйлчилгээг шинэчлэн зохион байгуулах тухай”

- А/67 –“Урамшуулал олгох тухай”

- А/77 –“Тусламж үйлчилгээ үзүүлэх тухай”

- А/97- “Сургалт зохион байгуулах тухай”

- А/99- “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”

- А/98- “Тусламж үйлчилгээ үзүүлэх тухай”

- А/104 –“Баяр наадмын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг зохион байгууцлах тухай”

- А/147 –“Тэмцээн зохион байгуулах тухай”

- А/145 –“ Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай”

- А/151-“Нийслэлд дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай”

- А/-“Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”

- А/180 –“Тайлан хүлээн авах тухай”

Сүхбаатар дүүргийн Онцгой комиссын албан даалгавар-1

- 01-“Гамшгаас хамгаалах дадлага сургуулилт зохион байгуулах тухай”

СБД-ийн Засаг даргын албан даалгавар-2

- Бүх нийтийн их цэвэрлэгээ хийх тухай”
- Шарилж, лууль цэвэрлэх ажил зохион байгуулах”

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын тушаал-1

- А/48 –“Данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай”

2019 оны 12 дугаар сарын 05-ны тус төвд нийт 393 буюу 1401 хуудас албан бичиг [erp.ulaanbaatar.mn](http://erp.ulaanbaatar.mn) системээр болон цаасан хэлбэрээр бүртгэгдсэн. Үүнээс 55 нь дээд газраас ирсэн тогтоол, тушаал, шийдвэр байсан. Ирсэн нийт бичгийн цаг тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан ба шийдвэрлэлт **99,65%**-тай байна.

### **9.1.3.ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**а/** Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой:

1.Засгийн газрын 150 дугаар тогтоолын дагуу 350 ажилтныг улирал тутамд 239.165.300 төгрөгийн цалингийн хувиар урамшуулсан. 7 ажилтныг 575.000 төгрөгийн дотоодын сургалтын зардлаар сургасан. Тэргүүлэх зэрэгтэй 6 эмчид 7.243.300 төгрөг, ахлах зэрэгтэй 11 эмчид 8.718.800 төгрөг, ахлах зэрэгтэй 10 сувилагчид 7.438.300 төгрөг, 134 жолоочид мэргэшсэн жолоочийн 120.404.200 төгрөгийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон.

2.Эмнэлгийн ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаанд 330 буюу нийт ажиллагсдын 81,4% хамрагдлаа. Судалгаанд хамрагдагсдын 97.5% нь ерөнхий сэтгэл ханамжид эерэг хариулт өгсөн. Ажилчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын ажилчдын дунд урлагийн наадам, спортын 4 төрөлтийн тэмцээн, эмч нарын баяр, сувилагч нарын баярын өдрүүдийг тэмдэглэсэн. Эмч, сувилагч нарын баяраар 45 эмч, 17 сувилагчийн ажлын үнэлж урамшуулал, НЭМГ, ЭМЯ-ны жуух, тэргүүн, өргөмжлөл болон бусад байгууллагуудын мөнгөн шагнал зэргээр урамшуулсан. Үүний үр дүнд эмнэлгийн ажилчдын ажиллах идэвх, урам зориг дээшилсэн.Эмч ажилчдын өдрийн хоолны меню болон хоолны амт чанар сайжирсан, мөн авто баазын ажилчдын хувцас угаах угаалгын газар, авто машин угаах газруудыг тохижуулсан зэрэг нь ажиллах сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн.

3. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг улиралд нэг удаа авч, судалгаанд нийт 325 үйлчлүүлэгч хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын 92.0% нь ерөнхий сэтгэл ханамжид эерэг хариулт өгсөн. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд үйлчлүүлэгчийн 7 эрхийг хангаж ажиллаж байгаа эсэхэд үнэлгээг 50 үйлчлүүлэгчээс авсан. Түргэн тусламжийн үйлчилгээ хурдан шуурхай үйлчилсэн, эмнэлгийн тусламжийг сайн үзүүлсэн, зөв оношилсон, харилцаа хандлага сайн байсан зэрэг талархлыг санал асуулгад оролцогсод талархаж өгсөн байна. Судалгаанаас харахад манай байгууллага үйлчлүүлэгчийн 7 эрхийг хангаж ажиллаж байна гэж дүгнэсэн.

4. Нийт жолооч нарын дунд амилуулах тусламж, автомашины ариутгал халдваргүйтгэл, автомашины тоног төхөөрөмжийн ашиглалт хадгалалт хамгаалал, хаяг болон замын хөдөлгөөний дүрмийн сургалт, ёс зүй, харьцаа хандлагын сургалтыг системчлэн байнга явуулж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 18 удаагийн нийт 108 цагийн сургалт зохион байгуулж үр дүнг дүгнэн ажилласан.

5. Түргэн тусламжийн байнгын бэлэн байдлыг хангах, ариутгал халдваргүйтгэлийн журмын дагуу автобаазын засварын цехэд автомашины ариутгал, халдваргүйтгэлийн цэг байгуулж автомашины ариутгалыг өдөр тутамд хийж хэвшсэн.

6. Шинэ болон сэргэж буй халдварт өвчин, менингококкцеми, хачгаар дамжих халдварт өвчин, тоосны шалтгаант харшлын өвчин сэдвээр мэргэжлийн эмч мэргэжилтнүүдийг урин лекц нийт давхардсан тоогоор 500 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Мөн Баянхонгор аймгийн 5 эмч эмнэлгийн мэргэжилтэн болон шинээр ажилд орж байгаа 8 эмчид халдвар хамгааллын дэглэм, хууль тогтоомжийн тухай сургалтыг зохион байгуулсан. 30 жолооч нарт автомашин ариутгах 2 хувингийн аргаар сургалт

8. Захирлын тушаалаар ажилчдын ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн улирлын ажлыг дүгнэж давхардсан тоогоор 350 ажилтанд 239.165.300 төгрөгийн урамшуулал олгосон.

9. Сар бүрийн батлагдсан төсвийн хуваарийн дагуу байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг зардлын бүлэг, зүйл ангийн зориулалтын дагуу зарцуулж сар бүрийн эхний ажлын өдөрт багтаан төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын 2 төрлийн мэдээ тайланг өмнөх оны 1, тухайн оны 5 сар дуустал хугацаанд нь тайлагнасан.

10. УСНББОУС-ын дагуу НББ-ийг хөтлөн санхүүгийн бүртгэл, тооцоог санхүүгийн тооцоолох программ хангамжид тасралтгүй бүртгэн явуулж байна.

**б/**Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган ажилласан. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 10 хавсралтад заасан арга аргачлалыг баримталж ажиллаж байна.

1. Хүний нөөцийг чадавхжуулах:


1.1. Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт

а/ Дотоод сургалтын тоо: нийт 397 ажилчдад 88 удаагийн 196 цагийн мэргэжлийн сургалт, 64 удаагийн 160 цагийн англи хэлний сургалт, 12 удаагийн 96 цагийн ХӨЦМ-ийн сургалтуудыг тус тус зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласан.

1.2. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

а/ Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо-385. Засгийн газрын 150 дугаар тогтоолын дагуу давхардсан тоогоор 350 ажилтныг 239.165.300 төгрөгийн цалингийн хувиар урамшуулсан.

2019 онд тус төвд Клиникийн пропессор цолоор 5 их эмч, Хөдөлмөрийн хүндэт медалиар 1 жолооч, ЭХТАжилтан цол тэмдгээр 3 ажилтан, ЭМЯамны жуух бичгээр 1 ажилтан, НЭМГ тэргүүний ажилтан цол тэмдгээр 2 ажилтан шагнагдсан.




б/ Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв харгалзан нийт 143.804.600 төгрөгийн цалин урамшуулал олгосноос ур чадварын нэмэгдэл 235 ажилтанд, зэргийн нэмэгдэл 27 эмч сувилагч, мэргэшсэн 134 жолоочид олгосон.

в/ Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх- 405 ажилтанд өдөрт 2 удаа нэг, хоёр дугаар хоол өгдөг. Унааны мөнгө ажилдаа ирж буцах 1000 төгрөг олгодог ба 2019 онд 412.518.100 төгрөг зарцуулсан.

г/. Нийслэлийн Түргэн тусламжийн төв нь ажилчид болон иргэдээс ирсэн өргөдөл хүлээн авч, цаг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. 2019 оны 12 сарын 02-ны байдлаар иргэд, ажилчдаас 193 өргөдөл бүртгэгдсэнээс ажлаас гарах 60 өргөдөл, ажилд орохыг хүссэн 15, тэтгэмж тусламж хүссэн 13, чөлөө хүссэн 87, бусад 18 өргөдөл ирснийг цаг хугацаанд нь шийдвэрлэж хариуг өгсөн.

### Өргөдлийн тоог 2018 онтой харьцуулж графикаар үзүүлбэл:



Ажилчдаас ирсэн өргөдлийн дагуу 17 ажилтанд 3965700 төгрөгийн цалинтай чөлөө, 15 ажилтанд 14.468.600 төгрөгийн тэтгэмж тусламж олгосон.


Улирал	Өргөдлийн тоо		Шийдвэрлэлт			
	Тайлангийн улиралд	Тайлант улирлын байдлаар өссөн дүнгээр	Шийдвэрлэж хариу өгсөн	Хугацаа хэтрүүлсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Шийдвэр -лэлт%
1	50	-	50	-	-	100%
2	45	-	45	-	-	100%
3	37	-	37	-	-	100%
4	61	-	61	-	-	100%

### Өргөдөлийн агуулга

№	Төрөл	Өргөдөлийн нийт тоо	Нийт өргөдөлд эзлэх хувь
1	Ажилд орох	15	7%
2	Ажлаас гарах	60	31%
3	Чөлөө хүссэн	87	46%
4	Тэтгэмж тусламж	13	6.7%
5	Бусад	18	9.3%

“Улаанбаатар ERP” программаар иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг үзэхэд нийт 162 удаагийн хандалтаар 149 талархал, 13 гомдол ирсэн. Үүнээс Засгийн газрын 11-11 төвөөс 107, 1800-1200 оператороор дамжигдан 41, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 1, утсаар болон цахим хэлбэрээр 8, биеэр болон бичгээр 5 өргөдөл гомдол ирсэн байна.

Талархал, гомдлыг 2018 онтой харьцуулж графикаар үзүүлбэл:



**2019 онд 11-11 утсаар үйлчлүүлэгчдээс ирсэн талархал 65.8 хувиар нэмэгдсэн ба гомдол 62.0 хувиар буурсан нь түргэн тусламжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг анхааран эмч ажилчидтай өдөр тутам ажилласны илрэл юм.**

Талархлыг 152 дуудлагын их эмч, 58 сувилагч, 109 дуудлагын жолоочид, нийт давхардсан тоогоор 319 хүн авсан байна.

- Ирсэн талархлаас 22 нь хүүхдийн тусламж үйлчилгээтэй холбоотой, түүн дотроосоо оператор эмч, сувилагчид 11 талархал ирсэн онцлогтой байсан.
  - Талархлыг байгууллагын талархлын самбар, цахим сайтад байршуулж, эмч, сувилагч, жолооч нарт танилцуулан ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж, урамшуулж ажилласан.
  - Ирсэн талархлыг ирсэн өдөрт нь 1-3 минутад иргэнд хариуг явуулсан.
- Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг үзэхэд Засгийн газрын 11-11 төвөөс 5, 1800-1200 оператороор дамжигдан 6, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 1, биеэр 1, нийт 13 гомдол ирсэн.
- Гомдлыг судалж, шалгаж, хариуг хуулийн хугацаанд нь иргэдэд өгсөн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3-4 хоног.
- Ирсэн гомдлыг чиглэлээр нь үзэхэд:
- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой-5
  - Ёс зүй харьцаа хандлагатай холбоотой-8
- Гомдлын дагуу чанарын баг болон чанарын албаны хурлаар 15 удаа хэлэлцэн, чанарын талон 5 эмчид сануулах арга хэмжээ авч, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхээр хугацаат үүрэг даалгавар чиглэл өгч ажилласан.
- Ёс зүй харьцаа хандлагатай холбоотой 8 гомдлоос 6 нь хүүхдийн мэдээлэл хүлээн авагчтай холбоотой буюу харьцаа хандлагатай холбоотой, дуудлагыг шууд аваагүйгээс үүссэн байсан.
  - 2, 3 дугаар улиралд гарсан гомдлыг Удирдлагын зөвлөлийн өргөтгөсөн хурлаар танилцуулан, хэлэлцсэн.

- Байгууллагад ирсэн гомдлыг бууруулах, эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
- Эмнэл зүйн тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг 7 удаа
- Мэргэжлийн ур чадварын тэмцээн 3 удаа
- Үзүүлэх сургууль 2 удаа
- Эмнэл зүйн сургалт, хэлэлцүүлэг 5 удаа зохион байгуулсан.
- Ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулахаар 4 удаагийн 4 цагийн сургалтыг давхардсан тоогоор 398 эмч сувилагч нарт зохион явуулсан.

Үр дүнд нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой иргэдээс ирэх санал гомдол буурч, талархал нэмэгдсэн.

д/ Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24 өдрийн А/335 дугаар захирамж “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 9.1.3-ын д/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, 9.1.4-ын а/ байгууллагын ил тод байдлыг үнэлэх ажлын хүрээнд;


- ❖ Тус төв нь бүх нийтийн их цэвэрлэгээг Төв, Хан-Уул салбар, Сонгинохайрхан салбар, Баянзүрх салбар, Автобааз 5 салбар нэгжид тус бүр хийж хог хаягдлыг Дүүргийн Тохижилт үйлчилгээний компанид тухай бүр ачуулсан. Дараах их цэвэрлэгээний дүнд нийт ойролцоогоор 4 тонн 300 килограмм хог хаягдлыг цэвэрлэн ачуулсан.
  - “Цагаан сарын баярын бүх нийтийн их цэвэрлэгээ”
  - “Их цэвэрлэгээний 90 минут “бүх нийтийн их цэвэрлэгээ”
  - “Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээ”



- ❖ Нийслэлийн Засаг даргын 03 дугаар албан даалгаврын хүрээнд Төв, Хан-Уул салбар, Сонгино-Хайрхан салбар, Баянзүрх салбар, Автобааз гадна талбайг тохижилтын ажлыг хийсэн.



Өмнөх дараах харьцуулсан зургууд:



Бүх нийтийн их цэвэрлэгээг 2018 оны хагас жилд хоёр удаа хийсэн. 2018 оны 2 сарын 10,11,12-д гурван өдөр тус бүр 2 цаг “Сар шинийн бүх нийтийн их цэвэрлэгээ”-г зохион байгуулж гадна болон дотор талбайд цэвэрлэгээ хийсэн. 4 сарын 21- ний өдөр "Их хотын цэвэрлэгээ 90 минут" их цэвэрлэгээг 90 минутын турш гадна талбайн цэвэрлэгээ, хашаа хашлага угаах, гадна цонх, довжоо зэргийг угаах ажлуудыг хийсэн. Уг хоёр удаагийн их цэвэрлэгээнд төв болон салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчид давтагдсан тоогоор 418 хүн оролцсон. Нийт 515м<sup>2</sup> талбайг цэвэрлэж 21м<sup>3</sup> хогийг хот тохижилтын компанид ачуулж



хамтран ажилласнаар хоггүй цэвэр орчныг бүрдүүлсэн.

Тарваган тахал өвчнөөс сэргийлэх мэдээлэл сурталчилгааг байгууллагын [www.103.ub.gov.mn](http://www.103.ub.gov.mn) сайтад тавьж байршуулсан. Салбар бүр дээр тарваган тахал өвчнөөс сэрэмжлүүлэх 14 зурагт хуудас 45 ширхэг боршур материалыг тарааж байрлуулсан.

Эмнэлгийн нийт эмч, сувилагч, жолооч, үйлчилгээний ажилчдын дунд “Эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлэх, гар угаах, халдваргүйжүүлэх, халдварын сэргийлэлтийн чанарыг сайжруулах аяныг 2017 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны хооронд зохион байгуулсан. Нийт 314 эмч, эмнэлгийн ажилчид оролцсон.

Аяныг зохион байгуулснаар гарын эрүүл ахуйн халдваргүйтгэл, гар угаах дадал хэвшил болж, халдвар хяналтын дэглэм сайжирсан тустай ажил болсон.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02/10 дугаар албан даалгаврын хүрээнд тус төвийн ажилчид байгууллага орчмын 50 м зам талбай, хашаа хайс, ногоон байгууламж, явган хүний зам, байгууллагын дотор хаалга, цонх, хана зэргийг угааж цэвэрлэн, гадна талбайн хог хаягдал, шарилжийг түүж их цэвэрлэгээ хийлээ. Цэвэрлэгээнд захиргааны болон үйлчилгээний ажилчид хамрагдсан.



Нийслэлийн засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” А-920 дугаар захирамж гарсан бөгөөд уг захирамжийн хэрэгжилтийг хангуулахаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” А/257 дугаар тушаалыг үндэслэл болгон Нийслэлийн түргэн тусламжийн төв нь Туул голын эрэг орчмын 800м газар бүхий зам талбайг 45 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр 21 шуудай хогийг цэвэрлэсэн. Мөн тус байгууллагын Төв, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Авто баазын салбарууд өөрсдийн харьяа 50м газрын зам талбайн хогийг цэвэрлэлээ.





Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 61 дүгээр тогтоолын дагуу тус төв орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цас мөс, хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Авто баазын салбарууд өөрсдийн харьяа 50м газрын зам талбайн хогийг цэвэрлэлээ.



Ололттой тал: “Нэгдсэн ариутгалын хэсэг” Хан-Уул салбарт байгуулж үйл ажиллагаа жигдрэн ажиллаж байна. Ариутгалд орчин үеийн технологи туршлага нэвтрүүлэх, хяналтыг тогтмолжуулах /биологийн индикатор улиралд 1, bowie dick сард 1, хяналтын индикатор өдөр бүр/ үүднээс дээрх хяналтуудыг заасан хугацаанд нь тогтмол хийн ажиллаж байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын төв лабораторитой гэрээ байгуулан улирал бүр дотоод орчны шинжилгээнд хамруулж ажиллаж байна. Үр дүнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гаргаагүй ажиллаж байна.

#### **9.1.5. ТАВДУГААР БҮЛЭГ - БУСАД МЭДЭЭЛЭЛ:**

##### **а/ Амилуулах суурь тусламжийн сургалтын талаар:**

Амилуулах суурь болон лавшруулсан сургалтыг тогтмолжуулан үр дүнг тооцох хүрээнд 2019 онд нийт Нийслэлийн эрүүл мэндийн харьяа 11 байгууллагын эмч, сувилагч, эрүүл мэндийг ажилтан нарт давхардсан тоогоор 24 удаагийн сургалтыг явуулсан 226 цагийн сургалтыг хийсэн ба нийт сургалтад оролцсон эмч, сувилагч, эрүүл мэндийг ажилтны тоо өмнөх 2018 оныхоос 75 эмч, сувилагч, эрүүл мэндийг ажилтнаар өссөн байна.

Сургалтын ур чадварыг 25 асуулттай сорилоор оролцогч болгоны дүгнэсэн ба сургалтын өмнөх сорил 48,3% байсан сургалтын дараа 76,5% тай болж ахиц 28,2% тай болж өссөн.

Нийт сургалтад оролцсон ажилтны тоо 3560 өмнөх 2018 оныхоос 410 ажилтнаар өссөн байна. Сургалтын ур чадварыг 20 асуулттай сорилоор оролцогч болгоны дүгнэсэн ба сургалтын өмнөх сорил 55,3% байсан сургалтын дараа 72,5% тай болж ахиц 17,2% тай болж өссөн сургалт үр дүгтэй харуулж байна

Амилуулах суурь тусламж болон гэмтлийн анхан шатны сургалтыг дотоодын сургалтад нийслэлийн түргэн тусламжийн төвийн дуудлагын их эмч, дагалдан эмч, сувилагч болон жолооч, дагалдаг жолооч нарт үе шаттай зохион байгуулсан.

Төрийн болон төрийн бус байгууллагуудад анхны тусламж сэдвээр сургалтуудыг явуулсан Үүнд: Сонгино хайрхан дүүргийн 7-р хорооны /1-5 20 22/ ӨЭМТ ,Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэл,Сонгинохайрхан дүүргийн гамшгийн багийн эмч, ажилчид, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 409-р ангийн ажилчдад,Нэгдсэн үндэсний байгууллагын монгол дах суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтнүүдэд, Үр шилжүүлэн суулгах Өөжинмед эмнэлгийн эмч ажилчдад,Himalaya компанийн санаачилгаар нийслэлийн ӨЭМТ-үүдийн эмч нар, Очирваань эмнэлгийн эмч эмнэлгийн ажилчид,Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 8 иогийн дасгалын төвийг багш ажилчдад, Улаанбаатар төмөр замын зангилааны хөдөлмөр хамгааллын инженерүүдэд, Аego-mongolia компанийн инженер техникийн болон үйлчилгээний ажилчдад, Төрийн банкны Улаанбаатар хот дахь салбаруудын менежерүүдэд, Улаанбаатар хот болон бусад аймгуудад үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн зуслангийн удирдлага болон багш нар.

2019 оны 01 сарын 10 -аас дагалдан их эмч нарт Амилуулах суурь болон лавшруулсан тусламж, эмнэлэг хүртэлх гэмтлийн лавшруулсан тусламж болон шархны анхдагч цэгцлэлт сэдвээр онол болон дадлага хослуулсан сургалт орсон. 2019 онд нийт 62 дагалдан эмч нарыг дээрх сургалтад хамруулж 20 удаагийн 168 цагийн сургалтыг явуулсан ба сургалт өмнөх сорил 53% байсан сургалтын дараах сорил тест 78% ахиц 35% байсан. 2019 онд дагалдан нийт 45 эмч нарт 15 удаагийн 120 цагийн сургалтыг зохиож үр дүнг удирдлагуудад танилцуулсан.Сургалтыг өмнөх сорил тест 48% байсан сургалтын дараах сорил тест 76% ахиц 30% байсан.

2019 онд эмч нарын дутагдалтай байсан дагалдан 62 эмчийг дадлагажуулж дуудлагын их эмчээр ажилд авсан. 2019 онд дуудлагын их эмч тогтвортой байсан нь 40 дагалдан эмч нарыг дадлагажуулан авсан.

Хичээлийн агуулга:

- Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт
- Эрэмбэлэн ангилах зарчим
- Хавсарсан хүнд гэмтлийн үнэлгээ
- Зөөлөн эдийн гэмтэл шархны үнэлгээ Gustilla Anderson ангилал
- Шарх, шархны тухай ерөнхий ойлголт
- Шарханд анхдагч цэгцлэлт хийх
- Амилуулах суурь тусламж
- Амилуулах лавшруулсан тусламж

- Нярайн сэхээн амьдруулах тусламж
- Эмнэлгийн аюултай хог хаягдал
- Гар халдваржуулах дадал

2019 оны 01 сарын 19-24-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 7 хорооны /1-5, 20, 22/ өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 95 эмч эмнэлгийн ажилчдад “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.

Сургалтыг Дэлхийн зөн ОУ-ын байгууллагын Монгол дахь салбар төвтэй хамтарч зохион байгуулсан.



Сургалтын хүрээнд дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан:

- Амилуулах суурь тусламж
- Амилуулах лавшруулсан тусламж
- Гэмтлийн суурь тусламжийн ерөнхий ойлголт, ангилал
- Эрэмбэлэн ангилах зарчим
- Хавсарсан хүнд гэмтлийн үнэлгээ
- Хүүхэд, нярайн амьсгалын замыг чөлөөлөх тусламж
- Яаралтай тусламжийн үед хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, эмнэлгийн аюултай хог хаягдал, гар халдваргүйжүүлэх дадал



Сургалтад хамрагдсан эмч, сувилагч нараас сургалтын өмнөх болон дараах сорил авсан. Сургалтын үр дүнг 20 асуумжтай сорил авсан ба сургалтын өмнө 48.6%, сургалтын дараах үнэлгээ 72.8% болж, ахиц 24.2%-ийн үр дүнтэй болсон.

- 2019 оны 03 сарын 21-ний өдөр Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн 60 эмч эмнэлгийн ажилчдад “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.



Сургалтад хамрагдсан эмч, сувилагч нараас сургалтын өмнөх болон дараах сорил авсан. Сургалтын үр дүнг 20 асуумжтай сорил авч үнэлсэн ба сургалтын өмнөх үнэлгээ 49.5%, сургалтын дараах үнэлгээ 68.4% болж, ахиц 18.9%-ийн үр дүнтэй болсон.

- 2019 оны 03 сарын 15-нд үр шилжүүлэн суулгах Өөжинмед эмнэлгийн 25 эмч эмнэлгийн ажилчдад “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.



Сургалтад хамрагдсан эмч, сувилагч нараас сургалтын өмнөх болон дараах сорил авсан. Сургалтын үр дүнг 20 асуумжтай сорил авч үнэлсэн ба сургалтын өмнөх үнэлгээ 51.5%, сургалтын дараах үнэлгээ 80.1% болж, ахиц 28.6%-ийн үр дүнтэй болсон.

- 2019 оны 03 сарын 22-23-ны өдрүүдэд Очирваань эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилчдад “Гамшгаас сэргийлэх төлөвлөлт, Гамшгийн үеийн яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.



Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан. Дадлага сургуулиллаар дараах сэдвүүдийн хүрээнд багаар ажилласан.

- Амилуулах лавшруулсан тусламж
- Гэмтлийн суурь тусламжийн ерөнхий ойлголт, ангилал PHTLS удирдамж
- Эрэмбэлэн ангилах зарчим
- Хавсарсан хүнд гэмтлийн үнэлгээ, JATEC 2015 удирдамж
- Яаралтай тусламжийн үед хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, эмнэлгийн аюултай хог хаягдал, гар халдваргүйжүүлэх дадал
- AED ажиллуулах дараалал, зарчим
- Түлэгдлийн үеийн анхны тусламж /burn-shield/
- Гамшгийн тухай ойлголт
- Гамшгийн үед ажиллах удирдлагын бүтэц, хээрийн эмнэлэг дэлгэж ажиллах
- Хээрийн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, осолдогч нэрвэгдэгчдийг хүлээж авах, шилжүүлэх
- Эмнэлгийн тусламжийн эрсдэл, эрсдлийн менежмент
- Гамшгийн үеийн эрүүл мэндийн штабын бүрэлдэхүүн, журам

2019 оны 04 сарын 16-ны өдөр “Түргэн Тусламжийн Амилуулах Нийгэмлэг” ТББ, LOTUS YOGA төвтэй хамтран нийслэлд үйл ажиллагаа эрхэлдэг 8 иогийн төвийн 20 багш ажилчдад “Амилуулах суурь тусламж /CPR+AED/” сэдэвт 8 цагийн сургалтыг зохион байгуулсан.



Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан. Дадлага сургуулиллаар дараах сэдвүүдийн хүрээнд багаар ажилласан.

- Амилуулах суурь тусламж
- Эрэмбэлэн ангилах зарчим

2019 оны 04 сарын 16-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Гамшгаас хамгаалах штабын багийн 14 эмч, ажилчдад “Гамшгаас сэргийлэх төлөвлөлт, Гамшгийн үеийн яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.



Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан. Дадлага сургуулиллаар дараах сэдвүүдийн хүрээнд ажилласан.

2019 оны 04 сарын 18-ны өдөр УБТЗ-ын зангилааны ХАБ инженеруудад “Гамшгаас сэргийлэх төлөвлөлт, Гамшгийн үеийн яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад зангилааны 14 ХАБ мэргэжилтэн оролцсон.



Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар

ажилласан. Дадлага сургуулиллаар дараах сэдвүүдийн хүрээнд багаар ажилласан.

Сургалтаар үйлдвэрлэлийн осол, гэмтэл түүний механизм, эрсдлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх сэдвээр хичээл орсон. Мөн ослын үеийн анхны тусламж, түүнийг зөв үзүүлэх талаар мэдлэг олгосон.

- Амилуулах суурь, лавшруулсан тусламж
- Гэмтлийн суурь тусламжийн ерөнхий ойлголт, ангилал
- Эрэмбэлэн ангилах зарчим
- Яаралтай тусламжийн үед хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, эмнэлгийн аюултай хог хаягдал, гар халдваргүйжүүлэх дадал

2019 оны 04 сарын 19-ны өдөр Aero-Mongolia компанийн жил бүр зохиогддог ээлжит давтан сургалтаар инженер техникийн болон үйлчилгээний 22 ажилчдад “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулсан.



- 2019 оны 05 сарын 13-ны өдөр ТББ, Төрийн банкны Улаанбаатар хот дахь салбар төвүүдийн 23 менежерүүдэд “Амилуулах суурь тусламж” сэдвийн хүрээнд 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.



Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан. Дадлага сургуулиллаар дараах сэдвүүдийн хүрээнд багаар ажилласан.

- Амилуулах суурь тусламж
- Гэмтлийн үеийн анхны тусламж
- AED төхөөрөмж, түүнтэй ажиллах
- Түлэгдлийн үеийн яаралтай тусламж

2019 оны 05 сарын 17-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 409-ээр ангийн ажилчдад “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулсан.

2019 оны 05 сарын 16-17-ны өдрүүдэд НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтнүүдэд “Анхны тусламж болон амилуулах суурь тусламж” сэдвийн хүрээнд 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.



2019 оны 05 сарын 24-ны өдөр НЭМГ, Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагаас “Анхны тусламж, Амилуулах суурь тусламж” сэдэвт сургалтыг “Түргэн Тусламжийн Амилуулах Нийгэмлэг” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад Улаанбаатар хот болон бусад аймгуудад үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн зуслангийн удирдлага болон багш нар, нийт 60 ажилтан хамрагдсан.



Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан. Дадлага сургуулиллаар дараах сэдвүүдийн хүрээнд багаар ажилласан.

- Амилуулах суурь тусламж
- AED ажиллуулах дараалал, зарчим
- Түлэгдлийн үеийн анхны тусламж /burn-shield/

2019 оны 05 сарын 24, 25-ны өдрүүдэд эм ханган нийлүүлэх HIMALAYA компанитай хамтран Нийслэлийн ӨЭМТ-үүдийн эмч нарыг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 25 эмч нарт “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдвийн хүрээнд 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.



Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан. Дадлага сургуулиллаар дараах сэдвүүдийн хүрээнд багаар ажилласан.

- Амилуулах суурь болон лавшруулсан тусламж
- Гэмтлийн суурь тусламжийн ерөнхий ойлголт, ангилал PHTLS удирдамж
- Эрэмбэлэн ангилах зарчим
- Хавсарсан хүнд гэмтлийн үнэлгээ, JATEC 2015 удирдамж
- Яаралтай тусламжийн үед хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, эмнэлгийн аюултай хог хаягдал, гар халдваргүйжүүлэх дадал
- AED ажиллуулах дараалал

Түлэгдлийн үеийн анхны тусламж /burn-shield

Дараах сэдвүүдээр онол, дадлага хосолж багаар ажилласан.

- Амилуулах суурь тусламж
- Автомат тохируулгат дефибриллятор, түүнтэй ажиллах зарчим

Дадлагаар ухаангүй осолдогчийг үнэлэх, амьсгал зүрхний үйл ажиллагааг дэмжих, амилуулах суурь тусламжийг зөв үзүүлэх талаар багийн ажиллагаа явуулсан.

Халдвар судлаачтай хамтран шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй халдвар хяналт сэргийлэлттэй холбоотой сургалтыг 5 дугаар сарын 28- 5 эмчид, жолооч нарт түргэн тусламжийн автомашиныг ариутгах, халдваргүйтгэх 2 хувингийн аргачлалыг 1 сарын 30-ний өдөр 29 жолоочид, 3 сарын 2-ний өдөр 7 жолоочид сургалтад хамруулсан. Шинэ эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг тухай бүрд сургалтуудад хамруулснаар мэдлэг чадвартай мэргэжилтэн, ажилтан бэлтгэгдэнэ.

Сургалтын алба болон тоног төхөөрөмжийн инженер, халдвар судлаачтай хамтран дараах сэдвээр онолын шалгалт авсан. Нийт 85 жолоочид автомашинд суурилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалт явуулсан.

- Амилуулах тусламж
- Автомашины ариутгал халдваргүйтгэл
- Автомашины тоног төхөөрөмжийн ашиглалт

Иргэд хөдөлмөрчдөд эрүүл мэнд, анхан шатны тусламжийн мэдлэг боловсрол олгох зорилгоор Түргэн тусламжийн амилуулах нийгэмлэгийн цахим хуудсыг ажиллуулж байна. Цахим хуудасны дагагчийн тоо 3600, цахим хуудасны 7 хоногийн дундаж хандалтын тоо давхардсан тоогоор 45000 удаа байна.

[https://www.facebook.com/Түргэн-тусламжийн-Амилуулах-нийгэмлэг-267160830846224/?modal=admin\\_todo\\_tour](https://www.facebook.com/Түргэн-тусламжийн-Амилуулах-нийгэмлэг-267160830846224/?modal=admin_todo_tour)

Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/19 дүгээр тушаалын хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн Түргэн Тусламжийн Төв, Нийслэлийн Эрүүл Мэндийн газар хамтран 2019.02.20-21-ны өдрүүдэд “Нийслэлийн цагдаагийн газрын харьяа эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч нарыг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангах, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх аргад сургах” нь сэдэвт сургалтыг 47 эмч нарт зохион байгууллаа.

Сургалтыг онол, дадлага хослуулан тус төвийн яаралтай тусламжийн эмч, багш нар удирдан сургалтын өмнөх ба дараах 25 асуулттай сорилоор дүгнэхэд эрүүлжүүлэхийн эмч нарын мэдлэг, ур чадвар 26,1%-р нэмэгдсэн нь газар дээр нь үзүүлэх тусламж үйлчилгээ сайжирсныг харуулсан юм. Уг





сургалтыг зохион байгуулснаар эмч нарын өвчтөнөө зөв үнэлэх, анхны тусламж үзүүлэх ур чадвар дээшилж, байгууллага хоорондын харилцаа холбоо сайжирсан.

Сургалтад хамрагдсан эмч, сувилагч нараас сургалтын өмнөх болон дараах сорил авсан. Сургалтын үр дүнг 20 асуумжтай сорил авч үнэлсэн ба сургалтын өмнөх үнэлгээ 51.5%, сургалтын дараах үнэлгээ 80.1% болж, ахиц 28.6%-ийн үр дүнтэй болсон.

2019 оны 03 дугаар сарын 19 нд БЗД Шиномед эмнэлэгт нийт 24 эмч,сувилагч нарт 6 цагийн сургалт хийв. “Нярайн сэхээн амьдруулалт, Насанд хүрэгчдийн сэхээн амьдруулалт, Гэмтлийн анхан шатны лавшруулсан тусламж” сэдвүүдээр сургалт орсон.


Сургалтад хамрагдсан эмч, сувилагч нараас өмнөх болон дараах сорил авсан. Сургалтын үр дүнг 20 асуумжтай сорил авсан ба сургалтын өмнө 36,5% байсан сургалтын дараа 71,5% ахиц 35% үр дүнтэй болсон.Шиномед эмнэлэгтэй 3 жил дараалан яаралтай тусламжийн цогц менежментээр үечилсэн сургалтууд хийгдэж байгаа. 2019 оны 03 сарын 30, 31 нд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирдлага болон ажилчдад хоёр удаагийн 8 цагийн сургалт орсон ба нийт 62 оролцогч хамрагдсан дараах сэдвээр Амилуулах суурь тусламж болон гэмтлийн үеийн суурь тусламжаар онол дадлага хосолсон ажлыг байрны сургалтыг орсон. Сургалтын өмнөх сорил тест 53% байсан сургалтын дараах сорил тест 79% ахиц 25% байсан.2019 оны 03 сарын 26-нд Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв болон Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран дараах сэдвээр: Амилуулах лавшруулсан болон Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт дээрх сэдвээр сургалт 2 өдрийн 16 цагийн сургалтыг явуулсан эмч, сувилагч нийт 86 ажилтан хамрагдсан. Сургалтыг өмнөх сорил тест 53,2% байсан сургалтын дараах сорил тест 78,5% ахиц 25,3% байсан.

Нийслэлийн бүс нутагт амралтын болон сувиллын газруудын эмч, сувилагч нарт эмнэлгийн анхан шатны тусламжийн сургалтыг зохион байгуулсан. Энхсаран сувиллын нийт 18 эмч, сувилагч хамрагдсан сургалтын өмнөх сорил 58,5% байсан сургалтын дараах сорил 82,3% ахиц 23,8 сургалт амжилттай болсон.


### **ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛСАН ТАЛААР:**

Байгууллагын цахим хуудсыг төлөвлөгөөний дагуу шинэ, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол шинэчлэн ажиллуулсан. Цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ мэдээлэл бүрэн багтсан. Үндсэн цэсийн танилцуулга хэсэгт үйл ажиллагааны эрхэм зорилго зорилт, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт зэрэг ил тод байдлыг хангасан 25 мэдээ мэдээллийг байршуулсан.

2019 онд байгууллагын А/50 тоот тушаалаар “Цахим хуудас ажиллуулах журам” боловсруулан батлуулсан.



Цахим хуудасны үндсэн цэсэд болон иргэдэд ойлгомжтой байдлаар нүүр хуудсанд багтсан ба тухай бүр шинэчлэн ажилласан. 2019 онд статистик мэдээлэл 56, хүний нөөцийн ил тод болон талархал гомдлын мэдээлэл 74, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл 61, бусад мэдээлэл гэх мэт нийт 291 мэдээ нийтлэгдэж, 308018 зочин хандсан байна. 2018 онд 175616 зочин хандсан бөгөөд энэ онд хандалтын тоо өмнөх жилээс 43%-өссөн үзүүлэлттэй байна.



Цахим хуудасны хандалтыг ихэсгэх зорилгоор шинэ мэдээ мэдээллийг тогтмол оруулж, мөн байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан мэдээлж байна.

- Байгууллагын Facebook хуудсаар нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, байгууллагын мэдээлэл, статистик мэдээлэл, зөвлөгөө, талархал, олон нийтийн ажил гэх мэт мэдээлэл оруулан ажиллаж байна.

- Одоогийн байдлаар 14.653 Like хүрсэн байна.

Тухай жилд байгууллагын цахим хуудсанд 263 мэдээ, мэдээлэл, зөвлөгөө, зарлал, бусад мэдээлэл байршуулсан.



Байгууллагын цахим хуудсыг иргэдэд сурталчлах зорилгоор дуудлагын эмч нарт тараах материал боршур зэргийг өгч дуудлага өгсөн айлд өгсөн. Мөн Facebook-ээр мэдээ мэдээлэл байршуулан сурталчилж ажилласан. Facebook-т сүүлийн үед их хандалттай байгаа Mr.Do пэйжийн админтай хамтарч “Түргэн тусламжийн автомашинд зам тавьж өгцгөө” сэдэвт видео шторк хамтран хийж маш олон хүний хандалт авсан.



Цахим хуудасны –Танилцуулга-Төрийн үйлчилгээ-Үйлчилгээний үнэ тариф – цэсэнд үнэ тарифтай холбоотой мэдээлэл байршуулсан.

Байгууллагын цахим хуудасны баруун хэсэгт өргөдөл гомдлын булан /Module/ нээж мэдээ мэдээллээр баяжуулсан. Өргөдөл гомдол хүлээн авах ажилтны мэдээлэл байршуулсан.

Тус онд амжилттай ажиллаж байгууллагын болон НЭМГ, ЭМЯ-ны шагнал авсан ажилчдыг алдаршуулж цахим хуудсанд байшуулсан.



Мөн ондоо цаг үетэй холбоотой мэдээ мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, сэрэмжлүүлэг зэргийг холбогдох хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, радио телевизүүдтэй хамтарч иргэдэд хүргэсэн.

- Цагаан сарын үеэр хордлого, гэмтэл, түлэгдэлтийн чиглэлээр сэрэмжлүүлэг сэдвээр Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Ариунболд С1, NTV, UBS, Эх орон тус тус ярилцлага зөвлөгөө өгсөн.
- “Томуу, томуу төст өвчний халдвараас сэргийлье” зөвлөмж болон томуу, томуу төст өвчний үед ажилласан тухай мэдээллийг тогтмол хүргэх мэдээллийг ХӨСҮТ-д [Eop@nccd.gov.mn](mailto:Eop@nccd.gov.mn) болон MJL-радио мэдээлэл чанарын албанаас тогтмол өгч ажилласан.
- MGL-Дэлхийн Монгол радиод “Гамшгийн бэлэн байдлыг хангах үүргэвчинд байх хүн нэг бүрийн бүрдэл”, “Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Хачигт халдвараас сэргийлье”, “Бөөрний архаг үрэвсэл үүсэх шалтгаан, хүүхдийн живхний хэрэглээ”, “Өсвөр насны охидын жирэмслэлт, БЗХӨ-ийн хор уршиг”, “Өсвөр насны охидын жирэмслэлт, БЗХӨ-ийн хор уршиг”, Тархины цус харвалт түүнээс сэргийлэх, хүүхдийн дуудлагын авахгүй байгаа талаар иргэний тавьсан асуултад эрэмбэлэн ангилах, түүнд үзүүлэх тусламж”, “Тамхины хор уршиг”, “Хоолны хордлого, түүнээс сэргийлэх”, “Наршилтаас урьдчилан сэргийлэх”, “Гэдэсний халдвараас сэргийлэх”, “Үер усны аюулаас сэргийлэх”, “Сурагчдын зуны урт хугацааны амралт эхэлсэнтэй холбоотой хүүхдээ анхаарах”, зэрэг сэдвүүдээр тус төвийн хүүхдийн чанарын менежер З.Энхцэцэг, “Архи тамхины хэрэглээ, түүний хор уршиг сэдвээр байгууллагын эмч А.Нарантуяа, “Зүрхний шигдээс өвчний талаар” чанарын менежер М.Цэрэнчимэд нар нийт 13 удаа мэдээлэл хүргэсэн.




- Угаарын хийн хордлоготой холбоотой мэдээллийг тухай бүрт нь “viber”-р мэдээлж ажилласан.

- НЭМГазартай хамтран “Угаарын хийн хордлогын үед авах арга хэмжээний зөвлөмж”-г боловсруулж холбогдох албад, нэгжүүдэд хүргэн, TV5, C1, ROYAL TV-р иргэдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгсөн.
- Тус төвийн их эмч Э.Одгэрэл, жолооч Т.Гүнтэвсүрэн нар ажил үүргээ гүйцэтгэх хугацаандаа гал түймрийн аюулаас 7 хүний амь насыг аварч үүнтэй холбоотой гал түймрийн аюулаас сэргийлэх, бага насны хүүхдүүдийг хараа хяналтгүй орхихгүй байх талаарх мэдээллийг TV5, C1, TV9, MNB, ROYAL TV болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр цацаж иргэдэд хүргэсэн.
- “Өнөөдөр” сонинд “Түргэн тусламжийн үйл ажиллагааны тулгамдсан асуудал”-р ярилцлага өгсөн.
- Цаг үетэй холбоотой мэдээ мэдээлэл, зөвлөмж санамжийг байгууллагын веб хуудас, цахим хуудас болон радио телевизүүдэд өгч ажилласан.


### **НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТАРСАН СУРГАЛТУУД**

2019 оны 04 сард Гачуурт, Хонхор, туул тосгоны ЭМТ Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран дараах сэдвээр Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт.

2019 оны 03 сарын 30, 31-нд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирдлага болон ажилчдад хоёр удаагийн 8 цагийн сургалт орсон ба нийт 62 оролцогч хамрагдсан дараах сэдвээр Амилуулах суурь тусламж болон гэмтлийн үеийн суурь тусламжаар онол дадлага хосолсон ажлыг байрны сургалтыг орсон. Сургалтын өмнөх сорил тест 53% байсан сургалтын дараах сорил тест 79% ахиц 25% байсан.




2019 оны 03 сарын 15 нд Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв болон Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран дараах сэдвээр нийт Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт сэдвээр сургалт давтан зохион байгуулсан. Сургалтыг өмнөх сорил тест 58% байсан сургалтын дараах сорил тест 82% ахиц 24% байсан.




2019 оны 04 сарын 06 нд Нарклогийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарт дээрх сэдвээр нийт 2 өдрийн 16 цагийн сургалт хамтран зохисон нийн 16 ажилтан хамрагдсан.


2019 оны 04 сарын 08-09 нд Шүд, эрүү нүүрний эмнэлгийн 48 эмч, сувилагч эмнэлгийн ажилтанд 2 өдрийн 16 цагийн яаралтай тусламжийн сэдвээр сургалт орсон сургалтыг өмнөх сорил тест 53% байсан сургалтын дараах сорил тест 78% ахиц 25% байсан.



2019 оны 04 сарын 11 нд Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв болон Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран дараах сэдвээр: Амилуулах лавшруулсан болон Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт дээрх сэдвээр сургалт 2 өдрийн 16 цагийн сургалтыг явуулсан эмч, сувилагч нийт 86 ажилтан хамрагдсан. Сургалтыг өмнөх сорил тест 53,2% байсан сургалтын дараах сорил тест 78,5% ахиц 25,3% байсан.



Нийслэлийн бүс нутагт амралтын болон сувиллын газруудын эмч, сувилагч нарт эмнэлгийн анхан шатны тусламжийн сургалтыг зохион байгуулсан. Энхсаран сувиллын нийт 18 эмч, сувилагч хамрагдсан сургалтын өмнөх сорил 58,5% байсан сургалтын дараах сорил 82,3% ахиц 23,8 сургалт амжилттай болсон.




[Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл.](#)


Эмч, эмнэлгийн ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаанд сувилагч 17, эмч 115, жолооч 85, бусад ажилчид 43, нийт 250 хүн хамрагдсан. Дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, ажлын аюулгүй байдал, дэмжлэгт орчин гэсэн 6 бүлэг 62 асуултаар судалгаа авсан. Судалгаанд оролцогсдын 68,8.0% нь байгууллагаараа бахархаж байна. Ерөнхий сэтгэл ханамж 48,2% нь сайн гэж хариулсан.

Дэмжлэгт удирдлага гэсэн бүлэгт байгууллагын дарга нарын удирдах арга барил 69,6% ,ёс зүй 65.2 % сайн гэсэн эерэг үзүүлэлттэй байна.


Өнгөрсөн онтой харьцуулахад 10.0%-аар өссөн нь удирдах албан тушаалтны багын ажиллагаа сайн байгааг харуулж байна.




Мөн 2019 онд байгууллагын онцлогт тохируулан тасаг нэгжийн удирдах арга барил асуултыг ээлжийн ахлагч, зохицуулагч нараар өөрчлөн хийсэн бөгөөд удирдах арга барил 76.8% хангалттай гэж үнэлсэн байна. Энэ 24 цагаар эмч, жолооч, сувилагч нартаа ажилладаг тул уялдаа холбоо, багаар сайн ажилладаг нь харагдаж байна.




Шийдвэр гаргалтад хамт олны оролцоо 61.2%, ҮЭ-ий оролцоо 39,6% байгаа нь өмнөх онтой харьцуулахад хамт олны оролцоо 5%-аар өссөн. Үйлдвэрчний эвлэлийн хороо 4%-р буурсан байгаа нь хамт олонд чиглэсэн болон үйл ажиллагааны ил тод байдал муу байгааг харуулж байна.




Байгууллагын санхүүгийн ил тод байдал 42,8% дунд үнэлгээг өгсөн байгаа нь эмч, ажиллагсад вэб сайтад орох мэдээлэл авах, шилэн данс шалгаж мэддэггүй байгаа нь үзүүлэлт дунд байгааг харуулж байна.




Байгууллагын мөнгөн тусламж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэлт сайн үнэлгээ 40,8% буюу өнгөрсөн жилээс 4%-р өссөн ч муу гэж өгсөн үнэлгээ 18% буюу өнгөрсөн онтой харьцуулахад 14,5%-р өссөн байгааг ажилчдын нийгмийн хамгаалал баталгааг хангахад чиглэсэн ажил сул байгаа нь харагдаж байна.



Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ өмнөх харьцуулахад сайн үнэлгээ 5%-р өссөн хэдий ч судалгаанд муу үнэлгээ өгсөн нь 6,2%-р өссөн байна, ажил дүгнэлтийг ил тод байлгах зарлалын самбарт байршуулах хэрэгтэй байна.



Удирдлагадаа санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж 14% муу үнэлгээтэй мөн 42,4% дунд үнэлгээтэй байгаа нь хамт олонтой нээлттэй санал бодлыг сонсох өдөр гаргаж ажиллахаар харагдаж байна.




Хүний нөөцийн хөгжих боломж мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх, ашиглах гэсэн үнэлгээнд 54,7% сайн гэж хариулсан нь урьд онтой харьцуулахад 3,0%-иар




илүү дээшилсэн эерэг сайн үзүүлэлттэй байна. Сургалтын нөөцийг судлаж эмч ажилчдаас санал асуулга авч төлөвлөгөө гарган ажиллаж байгаа нь сайн үр дүнг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан нийт ажиллагсдын хүний нөөцийн сонгон шалгаруулалтын ил тод байдал 49.2% тай өмнөх оноос 4% дээшилсэн байгааг ажилд шинээр орж байгаа эмч, ажилчдын сонгон шалгаруулалт ил тод байгааг харуулж байна. Хүний нөөцийн гадаад сургалтын ил тод байдал 44.4% гэж хариулсан нь дунд үнэлгээг өгч байна. Энэ нь гадаад орны хамтарсан төсөл хөтөлбөр үгүй, гадаад сургалтын төсөв тусгагдаагүй байдагтай холбоотой.




Мэргэжлийн болон эрдмийн зэрэг хамгаалах боломж өмнөх онтой харьцуулахад 4%-р өссөн байгааг сүүлийн жилүүдэд онол практикийн хурлыг тогтвортой зохион байгуулж байгаа нь ажлын байран дах судалгаа шинжилгээ сайжирч байгаа нь харагдаж байна.


Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг 24 цагаар хамтдаа ажилладаг эмч-зохицуулагч, эмч-жолооч, эмч-сувилагч гэж асуултыг гаргасан бөгөөд тус судалгаагаар ёс зүй 70-аас дээш хувьтай байгаа нь багаар ажиллах, нэг нэгнээ хүндэтгэх, мэндлэх, найрсаг харилцаа сайн байгааг харуулж байна.




Эмч эмнэлгийн мэргэжилтний хувийн соёл, энгэрийн тэмдэг, хувцаслалт 72.8% эерэг сайн үнэлгээ өгсөн байгаа нь хувь хүмүүсийн соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт 4 удаа явагдсаны үр дүн харагдаж байна. Хамт олны эв нэгдэл, хоорондын харилцаа 74.% сайн өмнөх онтой харьцуулахад 6%-р өссөн нь хамт олны дунд найрсаг харилцаа тогтоох спорт, урлагийн тэмцээн уралдаан зохион байгуулах, ажилчидтай холбогдох баяр наадмаар шагнал урамшуулал олгох зэрэг нь хамт олны найрсаг харилцаатайг харуулж байна.




Байгууллагын соёл гэдэг бүлэгт байгууллагын дотоод орчны соёл, тав тух гэсэн судалгаанд оролцогсдын 51.2% сайн гэж үнэлсэн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.2-аар буурсан үзүүлэлт өгсөн байна. Байгууллагын гадаад орчны тохижилт 48.4%, хүнд өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээ 50% дунд үнэлгээг өгсөн байна.




Байгууллагаараа бахархах сэтгэл 2018 онтой харьцуулахад 4%-аар өссөн эерэг үзүүлэлт гарсан байгаа нь хамт олны уур амьсгал, болоод байгууллагын үйл ажиллагаа ажилчдын төлөө ажиллаж байгаа нь харагдаж байна.




Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд судалгаанд оролцогсдын 54.4% сайн гэж үнэлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 1.7 %-аар өссөн эерэг үзүүлттэй байгаа нь эмч, жолооч нарын ажлын ур чадвар сайн байгааг харуулж байгаа ч сайжруулах шаардлагатай байна. Салбар ээлжүүдэд тусламж үйлчилгээний стандартыг мөрдүүлж ажиллах, сургалт явуулах хэрэгтэй харагдаж байна. Ажлын хариуцлага, шуурхай байдал 63.6% буюу өмнөх оноос 0.4%-р өссөн байгаа ч өмнөх онд муу үнэлгээг нийт судалгаанд хамрагдсдын 4.3% өгч байсан бол энэ онд 1.6% хувь болж буурсан нь сайн үзүүлэлт билээ.




Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж ажиллах:



Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах:




Оношилгоо, эмчилгээнд шинэ технологи нэр төрөл нэмэгдсэн байдал:



Ажлын байрны аюулгүй байдал, дэмжлэгт орчин:

Энэ бүлэгт өмнөх оноос үзүүлэлт эмнэлгийн халдвар хамгаалал 2.6% -аар буурсан, ажлын байрны тав тух, агааржуулалт, тохижилт 5%-аар буурсан буюу 37.6%-ын сайн үнэлгээг өгсөн. Ажиллагсдын хоолны газрын эрүүл ахуй, тохижилт 48.4%, ажлын байрны чийрэгжилт, алжаал тайлах нөхцөл 21.2% муу үнэлгээ өгсөн, алжаал тайлах нөхцөл 32.8 % сайн гэж үнэлж өмнөх оноос 6%-аар буурсан. Ерөнхий сэтгэл ханамж 48.8% тай гарсан байна.




Эрүүл Мэндийн Сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай 13 тоот тушаалын дагуу тус төвөөр үйлчлүүлсэн 164 үйлчлүүлэгчийг хамруулан сэтгэл ханамжийн судалгаа хийсэн.


Тус төв нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг улиралд нэг удаа авч, Төв, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул салбараар үйлчлүүлж буй 164 үйлчлүүлэгчдээс байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тэгш байдал, ашиг сонирхол гэсэн 4 бүлэг 21 асуултаар судалгаа авсан.

1. Судалгаанд оролцогсдын 81% нь 28-60 насны үйлчлүүлэгчид, 74% нь тус төвөөр 2 түүнээс дээш удаа үйлчлүүлсэн байна.


Байгууллагын ажилтны нэгдсэн загвар бүхий хувцаслалт, энгэрийн тэмдэг гэсэн асуултад энэ онд 93%-ийн сайн гэж хариулсан нь өмнөх оноос 3%-р өссөн нь байгууллагын эмч нарын биеэ авч яваа байдал болон дүрэмт хувцасны өнгө үзэмж сайн байгааг харуулж байна. Судалгаанд оролцсон нийт үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж манай байгууллагын үйлчилгээний талаар хангалттай эерэг үнэлгээ өгсөн байна.




Дуудлагад шуурхай ирдэг эсэх гэсэн асуултад энэ онд 81,2% өгсөн нь өмнөх оноос 5%-р өссөн сайн үзүүлэлттэй байсан. Иргэдийн замын хөдөлгөөний соёл, гэр хорооллын хаягжилт болон НТТТөвийн жолооч нарын ур чадвар сайн байгааг харуулж байна.



Байгууллагын эмч нарын үзлэг оношилгоо хийж тусламж хүргэх ур чадвар, хандлага 85,7% буюу өмнөх оноос 4%-р өссөн үзүүлэлттэй байна, энэ нь байгууллагын дотоод эмч нарын 7 хоног бүрийн тасралтгүй сургалтын үр дүнг харуулж байна.



2. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлыг судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчид дараах үзүүлэлтээр хангалттай эерэг үзүүлэлтээр үнэлсэн байгаа нь байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жолооч нарт сард нэг удаа “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлага” сэдэвт сургалтын зохион байгуулагддаг бөгөөд сургалтын үр дүн харагдаж байна.




3. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн 80.8% сайн хангалттай гэж үнэлсэн байна. Энэ байгууллагаас долоо хоног болгоны Лхагва гаригт эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг. Мөн шинэ орсон эмч нарыг дадлагажуулж ур чадварын шалгалт авдаг нь эмчилгээний чанар хүртээмж сайн байгааг харуулж байна.




4. Тэгш байдал, ашиг сонирхлын судалгаанд тусламж үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гардаг уу? гэсэн судалгаанд 94.% үгүй гэсэн бөгөөд 5.8% мэдэхгүй гэсэн үнэлгээ өгсөн нь шаардлага гардаггүй гэж байгаа нь түргэн тусламж төлбөрт

үйлчилгээ байдаггүйтэй холбоотой эерэг үзүүлэлт юм. Ерөнхий сэтгэл ханамж хангалттай эерэг үнэлгээг үйлчлүүлэгчид өгсөн байна.



Байгууллагын ерөнхий сэтгэл ханамж сайн 84% сайн гэсэн үнэлгээтэй үнэлэгдсэн байгаа нь иргэдийн сэтгэл ханамж эерэг сайн байгааг харуулж байна.



## САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Тус төвийн 2019 оны төсөв 8,072.0 сая төгрөгөөр батлагдан доорх зардлуудад хуваарилагдан зориулалтын дагуу зарцуулав.


Эрүүл мэндийн тухай хуулиар эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийг МУ-ын иргэнд төр хариуцах болсон тул үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тусгагдаагүй 100 хувь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжиж байна.

Үүнд:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж:

- Төсвийн ажиллагсдын цалин хөлс, хоол унааны нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-д нийт төсвийн 75.9 хувийг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, харуул хамгаалалтын гэрээт ажлын зардалд 4,5 хувийг,
- Түлш шатахуун, аж ахуйн хангамж, интернет шуудан холбоо, бичиг хэрэг, маягт хэвлэлт, хог тээвэрлэлт, ариутгал цэвэрлэгээнд 14.7 хувийг,
- Ажилчдын ажлын өвөл, зуны хувцас хийлгэхэд 0,2 хувийг,
- Эм, ороох боох материал, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур зэрэгт 2.3 хувийг,
- Эд хогшил, урсгал засвар, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс авахад 1.6 хувийг,
- Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах үзлэг, даатгал, татвар, бусад төлбөрт 0.9 хувийг эзэлж байна.

## БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ (мянган төгрөгөөр, хувиар)



Урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны тухай холбогдох хуулийн дагуу босго үнээс давсан худалдан авалтыг зохион байгуулах 3 төсөл, арга хэмжээг төлөвлөн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусган [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр нээлттэй, ил тодоор зарлан явуулж сонгон шалгаруулалтыг хийсэн.

Уг тендерт “Автомашин шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх”, “Ариутгал цэвэрлэгээ, хангамжийн материал”, “Багаж, техник хэрэгсэл” гэсэн нийт 229,1 сая төгрөгийн 3 тендерийг цахимаар явуулж МУ-ын ЗГ-аас 2019 он “Эх оронч худалдан авалт”-ын жил болгосонтой холбогдуулан зарим нэр төрлийн бараа, материалыг дотоодын бүтээгдэхүүний давуу эрхийг тооцохоор зохион байгуулж нийтдээ 13.7 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай гэрээ хийгдсэн.

### ➤ САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

1. “Шилэн дансны тухай” хууль, МУ-ын Сангийн сайдын 2017.12.14-ны өдрийн 363 тушаалаар батлагдсан “ТБОНӨХБАУХА тухай хуулийн ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын дагуу холбогдох сайт, самбарт мэдээллүүдийг ил тодоор мэдээлсэн.

Үүнд:

- а/ Санхүүгийн ил тодын байдлын самбарыг байгууллагын угтах хэсэгт байршуулж, мөн байгууллагын вебсайтад мэдээлбэл зохих үндсэн мэдээллүүд болон нэмэлт мэдээллийг дараах байдлаар мэдээлж байна.- Батлагдсан төсөв 1 удаа, төсвийн өөрчлөлт 1 удаа
- Төсвийн сар бүрийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан – 12 удаа /зөвхөн самбарт/



- 2018 оны бүтэн жил, 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн баланс, тайлан – 2 удаа

-Аудитын дүгнэлт иж бүрэн 29 хуудас – 1 удаа

- Хөрөнгө оруулалтын тайлан – 2 удаа

- Бусад мэдээлэл санхүүгийн эх үүсвэрийг зардлын бүлэг хооронд өр төлбөр барагдуулахаар гаргасан санал шийдвэрлэсэн ажлуудыг нэмэгдүүлэн ил тодоор мэдээлэв.



б/ “Шилэн дансанд байршуулбал зохих тайлан, мэдээ, файлуудыг дараах байдлаар мэдээлсэн:

- Өмнөх болон тухайн оны бүтэн жилээр 11 тайлан, мэдээлэл оруулахаас 6-г PDF файл хэлбэрээр, 5-г зохих маягтаар

- Хагас жилээр 4 тайлан, мэдээлэл оруулахаас 1-г PDF файл хэлбэрээр, 3-г зохих маягтаар

- Улирлаар өмнөх болон тухайн оны 1 мэдээллийг зохих маягтаар 4 удаа

- Сараар байршуулах 3 мэдээллийг өмнөх болон тухайн оны мэдээллийг 36 удаа мэдээллийг зохих маягт, нэмэлт PDF хэлбэрээр

- Тухай бүр тайлагнах 8 маягтаар тухайн оны 8 мэдээллийг 96 удаа маягтаар болон холбогдох материалыг PDF хэлбэрээр хавсарган толилуулсан.

➤ **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

1. ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 35 сая төгрөгийн зөөврийн ЭХО аппарат, 2 нэр төрлийн 35.7 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, 74.9 сая төгрөгийн түргэн тусламжийн автомашин /элэгдлийг анх хүлээн авч ашигласан хугацаанд нөхөн элэгдүүлэн бүртгэв/, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 358.4 сая төгрөгийн 4 нэр төрлийн эмнэлгийн тоноглолтой 3 автомашин нийтдээ 6 нэр төрлийн 504.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд орлогод бүртгэв.

**Хөрөнгө оруулалтын бүртгэл**

/сая төгрөг/

Хөрөнгийн нэр төрлөөр	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Гүйцэтгэгч байгууллага	Ашиглалтад хүлээж авсан огноо	Тайлбар /чанар ашиглалтын байдал/
Авто тээврийн хэрэгсэл	296.3	Нийслэлийн хөрөнгө оруулалт	2019	4 нэр төрлийн тоноглолтой 3 автомашин
Авто тээврийн хэрэгсэл	74.9	ЭМЯ	2019	Ашиглагдаж байсан
ЭХО аппарат	35.0	Мехатроник ХХК	2019	Шинэ -1ш
Дефибрилятор	48.6	Медимпекс интернейшнл ХХК, НҮСО ХХК	2019	Шинэ-7ш, 7ш
Хяналтын монитор	19.9			
Амьсгалын аппарат	25.7	НҮСО ХХК	2019	Шинэ-3ш
Сорох аппарат	3.6	НҮСО ХХК	2019	Шинэ-3ш
<b>Дүн</b>	<b>504.0</b>			



2. Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаанд тусгагдсан хөрөнгө оруулалтын ажлуудаас шинээр ашиглалтад орох Чингэлтэйн салбар төв дуусаж хүлээлцэх шатандаа явагдаж байна.

#### **Чингэлтэй салбарын товч танилцуулга**

Тус төвийн Чингэлтэй салбар төв нь 14 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Хайлаастын гудамжид 3-н давхар, 600м<sup>2</sup> талбайтай, урт нь 18м, өргөн нь 15м хэмжээтэй. 1-р давхарт 4 машины гарааштай, 2,3-р давхарт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх өрөө, серверийн өрөө, дуудлагын эмчийн өрөө, эм найруулах өрөө, эмч жолооч нарын өрөө, ажилчдын цайны газар, салбарын эрхлэгчийн өрөө тус тус байрласан.

Коридорийн хэсгийн хананууд шилэн хоргоор хүрээлэгдсэн, өнгө үзэмж сайтай, цахилгааны генератораар байрыг халаах зориулалттай баригдсан.



Гаднах нүүрэн тал



Өгсөх, уруудах шат



Цахилгааны генератор /халаалтыг цахилгаанаар шийдсэн эх үүсвэр/



2 давхрын коридор

#### **➤ АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДЛУУД, ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

1. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх уралдаан тэмцээн, спорт, бусад аян, арга хэмжээ, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал, ахмад өндөр настанд үзүүлсэн хүндэтгэлийн зардал, ажилчдын үр дүнгийн урамшуулалын зардалд

Үүнд:

- ✓ Хаврын уламжлалт байгууллагын спартакиадад 1,824.0 мянган төгрөг,
- ✓ НЭМГ-аас зохион байгуулсан “Шилжин явах цом”-ын зардалд 1,230.0 мянган төгрөг,
- ✓ Хүүхдийг эрхийг хамгаалах өдөрт 16,614.0 мянган төгрөг,
- ✓ Цагаан сараар 204 ахмад, өндөр настангуудад 2 удаа хүндэтгэл үзүүлэх 25,560.0 мянган төгрөг,
- ✓ Дээд байгууллагуудаас авсан 11 хүнд дагалдах шагналд 980.0 мянган төгрөг
- ✓ Эмч нарын тангараг өргөх ёслол, дэлхийн эмч нарын баярыг угтан зохион байгуулалтын ажилд 1,100.0 мянган төгрөг
- ✓ Сувилагч нарын баярын арга хэмжээнд 1,344.0 мянган төгрөг
- ✓ Ажилчдад улирлын ажлын үр дүн, урамшуулалд 239,165.3 мянган төгрөг,
- ✓ Нэг удаагийн болон цалинтай тэнцэх тэтгэмж 15 хүнд 14,468.6 мянган төгрөг
- ✓ Тэтгэвэрт гарч буй ажилтанд 1,020.0
- ✓ Өндөр настанд замын зардалд 165.0
- ✓ Байгууллагын 7 хоногийн тогтмол сургалт болон бусад зохион байгуулагдсан сургалт 11,382.9

Нийт дээ 314,853.8 мянган төгрөгийг зарцуулсан.

2. *Автомашин үзлэг, оношлогоо, даатгал, татварт* хамруулж автомашины бэлэн байдлыг бүрэн ханган ажиллав. Уг ажилд:

- тээврийн хэрэгслийн татварт 4,480.0 мянган төгрөг,
- үзлэг оношилгоонд 2,596.0 мянган төгрөг,
- тээврийн хэрэгслийн даатгалд 15.330.0 мянган төгрөгийн нийт 22,406.0 мянган төгрөг зарцуулав.

3. *Ажилчдын хоол, хүнсийг хөнгөлөлтийн талаар*: 1 удаад материалын үнэ өртгөөр тооцон 2 порц хоолыг 4000-4500 төгрөгөөр олгож өдөр, орой 24 цагт ээлжийн ажилчдыг халуун хоол, ундаар тасалдуулалгүй хангасан.

4. *Ажилчдын хувцас хангамж, зөөлөн эдлэл бэлтгэх талаар*: Эмч, жолооч нарын ажлын өвлийн 101 ш, зуны хувцас 72 ш 24,470.0 мянган төгрөг, захиргааны ажилчдын бэлэн байдлын хантааз 40 ш 1,400.0 мянган төгрөг, халаад 3 ш 135.0 мянган төгрөг, гамшгийн үеийн хээрийн бэлэн байдлын 28 иж бүрэн хувцсанд 6,860.0 мянган төгрөг, биеийн тамирын хувцас 32 ш 1,076.0 мянган төгрөг, бэлэн байдлын үүргэвч 41 ш 1,077.4 мянган төгрөг, тахлын хувцас 40 ш 2,178.0 мянган төгрөг нийт 37,196.4 мянган төгрөгөөр хийлгэж шийдвэрлэсэн.

#### ➤ **САНХҮҮЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ:**

1. Нийслэлийн дотоод аудитын газраас 2019 оны 07 сард хийгдсэн санхүүгийн хяналт шалгалтаар 4 зөвлөмжийг авч төлөвлөгөө гарган 72.4 хувьтай хэрэгжүүлж байна.

2. Төрийн аудитын газраас хуваарилсан “Цэгц төв богд” аудитын байгууллагаар 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шалгалтыг хийлгэн акт зөрчилгүй, зөвлөмжтэй бөгөөд “Стандарт” үнэлэлт дүгнэлт авсан. Уг зөвлөмжийг хэрэгжүүлэхээр 7 ажлын төлөвлөгөө гарган 84.3 хувийн хэрэгжилттэй ажиллаж байна.

3. Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт 215.4 сая төгрөгт нийлүүлэгдэхээр гэрээ хийгдэж нийлүүлэлтээс 13.7 сая төгрөгийн хэмнэлт, үр

ашигтай ажиллан уг хэмнэлт болон бусад зардлын бусад хэмнэлтээс 106.0 сая төгрөгийг байгууллагын өр төлбөр үүсэж болзошгүй шатахуун, эмийн зардал, өвөлжилтийн бэлэн байдал хангах, шинээр ашиглалтад орж буй Чингэлтэй салбар төвийн гаднах холбоо мэдээллийн кабелин сүлжээний угсралтын ажил, ажилчдын өвлийн хувцасны норм хугацаа дууссан хувцасны нөхөн хангалт зэрэг зардалд шилжүүлэн зарцуулахаар зохицуулалтыг 2 удаа хийлгэн төсвийн өр төлбөргүй байх зохистой удирдлагыг ханган хэрэгжүүлэв.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЙЛАН

Хүснэгт 1. Барилга, байгууламж засварууд

дд	Төсөл арга хэмжээний нэр	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр /төгрөг/				Гүйцэтгэгч байгууллага	Ашиглалтад хүлээн авсан огноо	Тайлбар /чанар ашиглалтын байдал/
		Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Төсөл Хөтөлбөр	Хандив тусламж			
<b>3.Урсгал засвар</b>								
3.1	Хан-Уул салбарын цэвэр усны шугамыг ХУ-ын нэгдсэн эмнэлгийн шугамаас тусгаарласан	2,032,100				Мэргэжлийн хувь хүнээр	2019.05 сар	Сантехникийн материал 1252,140 төг, ажлын хөлс 780,000 төгрөг
3.2	Автобаазын диспетчерийн байрны дэргэд сангийн слесарь нарт өрөө гаргасан	1,276,000				Өөрийн ажилчдын хүчээр	2019.02 сар	Барилгын материал авч өөрсдийн ажилчдын хүчээр шинээр хийж бэлтгэсэн.
3.3	Автобаазын харуулын байрны гадна талын өнгийг будаж сэргээсэн.	135,100				Өөрийн ажилчдын хүчээр	2019.02 сард	Гадна өнгө үзэмжийг сайжруулсан.
3.4	Автобаазын гадна зам талбайн эвдэрснийг нөхсөн	491,000				Өөрийн ажилчдын хүчээр	2019.05 сар	Урсгал засварын материал авч шинээр хийсэн.

3.5	Автобаазын цайны газар, Баянзүрх салбарын цайны газарт ширээ, түмбочка хийсэн.	539,150				Өөрсдийн ажилчдын хүчээр	2019.03 сар	Урсгал засварын материал авч шинээр хийсэн.
3.6	Автобаазын ажилчдын амрах саравч барьсан	238,300				Өөрсдийн ажилчдын хүссэнээр	2019.05 сар	Байгууламжуудын сангийн эвдрэл, гэмтлийг цаг тухайд нь зассан
3.7	Автобаазын узельд ялтсан бойлер, автомат клапан сольсон, БЗС-ын узелийн өрөөний урсгал засвар хийсэн	13,028,000				Гегатаун ХХК	2019.10 сар	Байгууллагын дулааны алдагдлыг арилгасан. Өвөлжилтийн ажлын бэлэн байдлыг хангасан.
3.8	5 салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлаар худгууд дулаалсан.	366,100				Өөрсдийн ажилчдын хүчээр	2019.10 сар	Шилэн хөвөн-198,0 хоолойн дулаалгын материал-168,1 татан авч өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан.
3.9	Байгууллагын 5 салбар, автобаазын гэрэлтүүлэг, цахилгааны засвар үйлчилгээг хийсэн.	2,393,000				Ажилчдын хүчээр	2019.09 сар	Урсгал засварын материалыг татан авч бүх гэрэлтүүлгийг ажиллагаатай хэвийн болгосон.

3.10	Засварын цехийн бүх өрөөг шохойдож хаалгануудыг будсан, конторын 1 давхрын үүдний ханыг тосон будгаар будсан.	1,194,000				Өөрсдийн ажилчдын хүчээр	2019.10 сар	Байгууллагын засварын цех, конторын коридорыг будаж өнгө үзэмжийг сайжруулсан.
3.11	Төв салбарын цайны газрын гарах хаалгыг шинээр сольсон.	150,000				Өөрсдийн ажилчдын хүчээр	2019.10 сар	Аваарын гарах хаалгыг шинээр сольсон.
3.12	Холбоо, кабель угсралтын ажлыг хийлгэсэн.	5,350,000					2019.11 сар	Шинээр ашиглалтад орж байгаа ЧД салбарын шилэн кабелийн холболтыг хийсэн.
	<b>ДҮН</b>	<b>27,192,750</b>						

#### 4. Хүснэгт 2.Тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмжийн төсөл	Тоног төхөөрөмжийн нэр	Марк загвар	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн огноо	Тоо хэмжээ	Нэгж үнэ/төгрөг/	Нийт үнэ / төгрөг/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр				Гүйцэтгэгч / нийлүүлэгч/ байгууллага	Ашиглалтад хүлээн авсан огноо	Тайлбар/чанар,ашиг лалтын байдал/
									Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Төсөл, хөтөлбөр/нэр тодорхой бичих/	Хандив тусламж			
1	Эмнэлгийн тоног төхөөрөмж														
1.3	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ														


1.3.1	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	ЭХО аппарат	ECO-6	хятад	2018	1	35,000,000	35,000,000	Улсын төсөв		Эрүүл мэндийн байгууллагыг тоног төхөөрөмжөөр хангах төсөл	ЭМЯ	2019.05	шинэ
1.3.2	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	Дефибрлятор	BT-8000A	хятад	2018	4	5,456,000	21,824,000	Улсын төсөв		Эрүүл мэндийн байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр хангах төсөл	ЭМЯ	2019.09	шинэ
1.3.3	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	Хяналтын монитор	BT-PM8B	хятад	2018	4	3,465,000	13,860,000	Улсын төсөв		Эрүүл мэндийн байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр хангах төсөл	ЭМЯ	2019.09	шинэ
1.3.4	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	Амьгалын аппарат	SD-H3000C	Хятад	2019	3	8,566,300	25,698,900	Улсын төсөв		Нийслэлийн хөрөнгө оруулалтаар НЭМГ-ын тендерээр	НҮСО ХХК	2019.11.25	шинэ
1.3.5	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	Дефибрлятор	DEFI EXPRESS-200	хятад	2019	3	8,923,200	26,769,600	Улсын төсөв		Нийслэлийн хөрөнгө оруулалтаар НЭМГ-ын тендерээр	НҮСО ХХК	2019.11.25	шинэ

1.3.6	Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	Хяналтын монитор	PM-9000	хятад	2019	3	2,000,000	6,000,000	Улсын төсөв		Нийслэлийн хөрөнгө оруулалтаар НЭМГ-ын тендерээр	НУСО ХХК	2019.11.25	шинэ
1.3.7	Эмнэлгийн тоног төхөөрөмж Сэхээ амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ	Сорох аппарат	SUCTION-7E-A	хятад	2019	3	1,200,000	3,600,000	Улсын төсөв		Нийслэлийн хөрөнгө оруулалтаар НЭМГ-ын тендерээр	НУСО ХХК	2019.11.25	шинэ
	<b>ДҮН</b>						<b>132,752,500</b>							
1.15	Бусад	Түргэн тусламжийн автомашин	Тоёото Гранвиа	Япон	2019	3	24,968,041	74,904,123	Улсын төсөв		ЭМЯ, УБ хотод байрлалтай эрүүл мэндийн байгууллагуудыг түргэн тусламжийн автомашинаар хангах	ЭМЯ	2019.05.20	Хуучин гүйшлт өндөртэй
1.15	Бусад	Түргэн тусламжийн автомашин	Форд Транзит	Хятад	2019	3	98,762,500	296,287,500	Улсын төсөв		Нийслэлийн Засаг даргын захирамж, НЭМГ-ын нээлттэй тендерээр	НУСО ХХК	2019.11.25	шинэ
	<b>ДҮН</b>						<b>371,191,623</b>							
	<b>НИИТ</b>						<b>503,944,123</b>							
	<b>/Тоног/төхөөрөмж/</b>						<b>531,136,873</b>							
	<b>Хөрөнгө оруулалтын нийлбэр дүн</b>						<b>531,136,873</b>							







#### 4. ERP – НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД УДИРДЛАГЫН СИСТЕМ.



Энэхүү нэгдсэн системийг байгууллагадаа нэвтрүүлэн, ажилчдад хэрэглэгчийн эрх үүсгэн ажиллаж байна. Уг системээр албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн удирдлага, албан бичгийн хөтлөлтийг хийж байна.

#### 5. SMARTCITY – ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН НЭГДСЭН СИСТЕМ.



Нийслэлийн удирдлагууд төрийн үйлчилгээ, мэдээллийг иргэдэд ил тод, түргэн шуурхай хүргэх, иргэдийн санал, хүсэлт, гомдол нэг бүрийг шуурхай шийдвэрлэхээр “Smart city” системийг нэвтрүүлсэн. Байгууллагын хүний нөөцийн алба болон чанарын албанд нэвтрэх эрх нээсэн ба уг системийг ашиглаж иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

#### 6. ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН “MONPASS”ПРОГРАМ.

Энэхүү систем нь албан бичиг төлөвлөлтөд удирдлагын цахим гарын үсгийг байршуулан ажилладаг.





## 7. БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭЛТИЙН “Joomla” НЭЭЛТТЭЙ ЭХИЙН ПРОГРАМ.



Тус программыг ашиглан байгууллагын цахим хуудсыг бүтээсэн ба тогтмол мэдээ мэдээлэл байршуулан ажиллаж байна.

## 8. “ARCHIVE eDOC” – АРХИВЫН ПРОГРАМ




Байгууллагын албан хаагчдаас үүсэж буй цахим баримтыг тус програмд архивлан эмх цэгцтэй хадгалдаг ба өдөр тутам ашиглаж байна.

## 9. “ACOLOUS” – НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ПРОГРАМ

Байгууллагын нягтлан бодогчид өдөр тутмын үйл ажиллагааны анхан шатны мэдээллийг бүртгэх, санхүүгийн мэдээ, тайлан гаргахад зориулагдсан, хамтдаа болон тус тусдаа бие даан ажиллах боломжтой дэд хэсгүүдээс бүрддэг програм юм.

## 10. “PAYROLL” – ЦАЛИНГИЙН ПРОГРАМ



## 11. ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭЛ, ЭВЛҮҮЛЭГ, БОЛОН БУСАД ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАМ ХАНГАМЖУУДЫГ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ БАЙНА.

- Adobe Master Collection
- Microsoft Office 2010
- Windows Server, Linux server, Windows OS
- After Effect
- Navigate 12 for MySQL – серверийн үйл ажиллагааг хянах програм
- Kaspersky - Хорт кодын эсрэг програм
- Бусад програм хангамжууд


## **БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Монгол улсын засгийн газрын 2013 оны 411 тогтоол Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 04 сарын 22-ны “Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн журам батлах тухай” 140 тоот тушаалыг үндэслэн байгууллагын цахим хуудас ажиллуулах журмыг боловсруулан Нийслэлийн түргэн тусламжийн төвийн захирлын 2019 оны 10 сарын 14-ний дугаар А/50 тоот тушаалаар “Цахим хуудас ажиллуулах журам”-ыг батлуулсан.

Байгууллагын цахим хуудасны үндсэн цэсний танилцуулга хэсэгт үйл ажиллагааны эрхэм зорилго зорилт, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт зэрэг ил тод байдлыг хангасан 25 мэдээ мэдээллийг байршуулсан. Цахим хуудасны үндсэн цэсэд болон нүүр хуудсанд иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээллүүд багтсан ба тухай бүр шинэчлэн ажилласан. Статистик мэдээлэл 56, хүний нөөцийн ил тод болон талархал гомдлын мэдээлэл 74, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл 61, бусад мэдээлэл гэх мэт нийт 291 мэдээ нийтлэгдсэн

**Цахим хуудасны хандалтын тоо:** 2019 онд 308018, 2018 онд 175616 зочин хандсан бөгөөд энэ онд хандалтын тоо өмнөх жилээс 43%-өссөн үзүүлэлттэй байна.

Өмнөх онтой харьцуулсан байдал:




Цахим хуудасны хандалтыг ихэсгэх зорилгоор шинэ мэдээ мэдээллийг тогтмол оруулж, мөн байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан мэдээлж байна. Ил тод байдлыг шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан ба цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ, мэдээлэл багтсан. Цахим хуудсанд эрх зүйн булантай ба үүнд байгууллага болон бусад холбогдох хууль тогтоомжууд нийтлэгдсэн.

**Цахим хуудасны шинэчлэлт:**

Байгууллагын цахим хуудсыг 2019 оны 06 сард бүтцийн шинэчлэлт хийсэн. Хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар зарим цэсийг нүүр хуудсанд байх тохиргоог хийж, мэдээлэл авах холбоосуудыг ил болгож өгсөн.

Мөн байгууллагын ажилчдад зориулсан албан хэрэг хөтлөлтийн хичээл заавар болон ERP, албан хэрэг хөтлөлтийн системийн шууд орох холбоосыг байршуулж өгсөн.

Байгууллагын цахим хуудсыг төлөвлөгөөний дагуу шинэ, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол шинэчлэн ажиллуулж байна. Цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ мэдээлэл бүрэн багтсан.



2019 онд байгууллагын цахим хуудсыг тогтмол шинэчлэн ажилласан. Цахим хуудсанд байгууллагын ил тод байдлын мэдээ мэдээлэл, иргэд үйлчлүүлэгчдэд хандсан нийгмийн эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, байгууллагын дотоодод болж буй мэдээлэл, чанарын булан, гадаад харилцаа, дуудлагын статистик мэдээлэл, сургалт сурталчилгаа, эрүүл мэнд, анхан шатны тусламжийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, хууль эрх зүйн зөвлөмж бичих болон байгууллага, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор өөрийн байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, үүсэл хөгжил гэх мэт мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна.

*Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага” MNS 6285:2011 стандарт, Засгийн газрын 2009 оны “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоолд нийцсэн байх:* Дээрх стандартын дагуу байгууллагын цахим хуудсанд мэдээ мэдээлэл байршуулах журам боловсруулан батлуулж журмын дагуу ажиллаж байна.

Цахим хуудсанд тавигдаж байгаа эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, нийгмийн эрүүл мэндийн мэдээ, зөвлөмж, заавар, тушаал, зэрэг бүхий л мэдээллийг Юникод ашиглан үсгийн фонтын алдаагүй нийтэлдэг.

Байгууллагатай холбоотой ил тод байдлын мэдээ, ашиглахад хялбар, видео, дүрс зураг, сургалтын файл зэргийг хэрэглэгчдэд журам стандартын дагуу цахим хуудсанд байршуулдаг.





### **Сошиал ил тод байдал:**

Байгууллагын Facebook хуудсаар нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, байгууллагын мэдээлэл, статистик мэдээлэл, зөвлөгөө, талархал, олон нийтийн ажил гэх мэт мэдээлэл оруулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар 14.653 Like хүрсэн байна.

### **“GPS” – АВТО МАШИНЫ ХЯНАЛТЫН ЦОГЦ СИСТЕМ:**



Нийслэлийн засаг даргын А/88 дугаар захирамжын дагуу нийслэлийн түргэн тусламжийн төвийн автомашинуудад хяналтын GPS систем нэвтрүүлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газраас зарласан тендерт BanqTech ХХК сонгогдож нийт 75 сая төгрөгийн үнэтэй “GPS хяналтын цогц системийг” нэвтрүүллээ. Уг байршил тодорхойлох систем нь Google Map-ийн газрын зураг дээр харуулдаг ба EIN /Emergency Information Network/ програмтай холбогдож ажилладаг.




Нийт 85 автомашинд “Meitrack T366” загварын хяналтын GPS суурилуулсан ба мэдээллийг үүрэн холбооны сүлжээгээр хяналтын сервер рүү дамжуулан төв болон салбаруудад хяналт тавин ажиллаж байна. GPS программыг нэвтрүүлснээр дотоод хяналт сайжирч, жолоочийн тооцоо, эмнэлэг үйлчилгээнд үйлчлэх автомашинуудын шуурхай байдал нэмэгдсэн. Мөн засвар үйлчилгээ хийлгэсэн дэлгэрэнгүй тайлан, автомашины хувийн хэрэгт хөтлөгдөх жолоочийн авсан шатахуун, явсан км, үйлчилсэн дуудлагын тоо, хийгдсэн бүхий л засвар үйлчилгээнүүд зэрэг жолооч болон автомашины дэлгэрэнгүй бүртгэлийг хялбараар гаргах боломжтой болсон юм.

### **ДОТООД ГАДААД СҮЛЖЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ:**

Төв, авто бааз, баянзүрх, сонгинохайрхан, хан-уул, чингэлтэй салбарууд бүгд дотоод сүлжээ болон гадаад интернэтийн нэгдсэн сүлжээнд холбогдсон. Байгууллагын дотоод сүлжээ байнга ашиглаж өөр хоорондоо сүлжээг ашиглан мэдээлэл, файл дамжуулан ашигладаг. Ингэснээр мэдээллийн урсгал сайжирч байна. Нийт дотоод сүлжээнд холбогдсон 124, төвд 29, Автобаазад 24, Баянзүрх салбарт 11, СХД салбарт 8, Хан-уул салбарт 7 байна.

Байгууллагын мэдээллийн урсгалыг нэг сүлжээнд оруулах, мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Төв болон Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-уул салбаруудыг төвийн дотоод сүлжээнд EIN сүлжээний дэд бүтцийг ашиглан холбож дуусгалаа.



Сүлжээний тасралтгүй байдал, аюулгүй байдлыг хангах зорилгоор сүлжээний “Firewall” төхөөрөмж суурилуулсан.




2019 оны 12 сард Чингэлтэй салбар ашиглалтад орж байгаатай холбоотой 6ш компьютер, 4ш IP утас, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг төлөвлөн ажиллаж байна. Тус салбарт шилэн кабелин сүлжээг татаж оруулсан. Ингэснээр Мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй шилэн кабелаар холбогдож яаралтай тусламжийн

дуудлага, мэдээлэл авах боломжтой болж байна. Гадаад болон дотоод сүлжээний ажиллагааг тестлэж жигдрүүлэх, програм хангамжийн суурилуулалт, дотоод сүлжээний тохиргооны ажлууд хийгдэж байна.



/Шилэн кабел суурилуулалт/

### НТТТ-ийн сүлжээний топологи зураг:



### МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТ:



Байгууллагын ажилчдын компьютерийг хорт кодоос хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор жил бүр лицензтэй програм суулгадаг. 2019 онд нийт 33ш “EsetNod32” анти вирусийн 1 жилийн лицензтэй програм суурилуулсан. Ингэснээр гадаад болон дотоод сүлжээ, зөөврийн флашны вирус зэргээс сэргийлж байна.

Мэдээллийн аюулгүй байдал болон бусад эрсдлийг тооцож ажилчдын хэрэгцээт файл болон зураг дүрс зэргийг CD, DVD-д бичиж архивладаг. Мөн хатуу дискэнд хуулж хадгалдаг.

Мөн сервер компьютерт сар, улирал тутам хуулж хадгалдаг.



**Хэрэглэгчийн компьютер гадаад сүлжээнээс вирусийн халдлагад өртөх, мэдээлэл алдагдах, мэдээллийн аюулгүй байдал зэргээс сэргийлж сүлжээнд тохиргоо хийж, зарим сошиал сувгийг хандалтыг хязгаарлав.**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолыг тус тус үндэслэн:

Байгууллын мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор байгууллагын ажилтан албан хаагчдын ажлын хэрэгцээний компьютерийн интернетийн сүлжээнээс олон нийтийн сүлжээний /Facebook, Twitter, Instagram, Youtube/ -ний сайтуудад нэвтрэх эрхэнд хязгаарлалт хийсэн.

#### **Нууцлал:**

- Байгууллагын сервер компьютерийн нууц үгийг өөрчилж, системийн шинэчлэлт хийсэн. Мөн гадаад интернетийн сүлжээг хааж тохиргоо хийж, дотоод сүлжээгээр ажиллаж байна.
- Байгууллагын нийт алба хаагчдын компьютерийн нууц үгийг шинээр сольж өгөв.

**Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлсэн байдал:**

Улсын хэмжээнд 4 жилд 1 удаа болдог “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн шалгалтад төлөвлөгөө гарган ажил зохион байгуулж амжилттай шалгуулж тэнцлээ. Уг үзлэгээр байгууллагын “Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл технологи нэвтрүүлсэн байдал”–г шалгуулж 97% хувиар “А” үнэлгээтэй дүгнүүлээ.

#### **Мэдээлэл технологийн сургалт:**





Эрүүл мэндийн яам, Цахим эрүүл мэнд төслөөс зохион байгуулсан нийт салбарын мэдээлэл технологийн мэргэжилтнүүдэд зориулсан “Мэдээллийн



сүлжээ, Аюулгүй байдал” сэдэвт 24 цагийн сургалтад хамрагдаж Сертификат гардан авсан.



- Гамшгийн үеийн бэлэн байдлын цугларах бүдүүвч болон байгууллагын төв, авто бааз, салбаруудын аврах гарцын схемийг шинэчлэн хийсэн.



**ОЛОЛТ АМЖИЛТ:**




- Ард иргэдийнхээ эрүүл энхийн манаанд хоёргүй сэтгэлээр зүтгэж, нойр хоолоо умартан ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн төлөөлөл болох Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн эмч Э.Одгэрэл, жолооч Т.Гүнтэвсүрэн нарыг Нийслэлийн Эрүүл мэндийн газраас “Хүний төлөө” медалиар шагнаж, нэг сарын цалинтай нь дүйцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэлээ. Энэхүү хүндтэй шагналыг Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн

бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаа, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар нар гардуулж өгсөн юм.Тэд албан үүргээ гүйцэтгэж явахдаа галын аюулд өртсөн долоон хүний амь насыг аварч, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлсэн бахархам гавьяаг байгуулсан билээ



Нийслэлийн Түргэн Тусламжийн төвд Нийслэлийн засаг даргын хөрөнгө оруулалтаар Форд Транзит маркийн бүрэн тоноглогдсон 3 автомашинаар нөхөн хангалт хийгдлээ. Автомашин хүлээлцэх, шинэ автомашины түлхүүр гардуулахаар Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар, Нийслэлийн Түргэн Тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш нар хүрэлцэн ирлээ.

- “Улаанбаатар ERP” программаар иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг үзэхэд нийт 162 удаагийн хандалтаар 149 талархал, 13 гомдол ирсэн. Үүнээс Засгийн газрын 11-11 төвөөс 107, 1800-1200 оператораар дамжигдан 41, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 1, утсаар болон цахим хэлбэрээр 8, биеэр болон бичгээр 5 өргөдөл гомдол ирсэн байна.



2019 онд 11-11 утсаар үйлчлүүлэгчдээс ирсэн талархал 65.8 хувиар нэмэгдсэн ба гомдол 62.0

хувиар буурсан нь түргэн тусламжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг анхааран эмч ажилчидтай өдөр тутам ажилласны илрэл юм.

- Нийслэлийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулж байгаа "Сайн туршлага -2019" өдөрлөгт Нийслэлийн Түргэн тусламжийн төв идэвхтэй оролцсон.



- Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээнд тэргүүн туршлага, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Сайн туршлага" арга хэмжээ 2019 оны 10 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулагдсан.

"Сайн туршлага" арга хэмжээнд 4 чиглэлээр 9 бүтээл оролцуулсан. Үүнд:

1. "Эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах, аюулгүй байдлыг шийдвэрлэн ажилласан бүтээл"-д 2 сайн туршлага
2. "Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бүтээл"-д 1 сайн туршлага
3. "Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологи"-д 2 сайн туршлага



"Шинээр боловсруулсан ном товхимол, удирдамж, гарын авлага, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр"-д 4 сайн туршлага.

Энэ арга хэмжээнд 42 байгууллагын 272 бүтээл өрсөлдсөнөөс Нийслэлийн түргэн тусламжийн "Яаралтай тусламжийн ампултай тарианы цүнх" шилдэг 20 бүтээлээр шалгарч батламж авсан. Мөн оролцсон 9 бүтээлд батламж гардан авсан.

- "ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ДУУ ХООЛОЙГОО НЭГТЭГЦГЭЭЕ" уриан дор "ЭРҮҮЛ АГААР-10000 АЛХАМ" иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг Богдхан уулын Чингисийн өргөө Ширээт хадны энгэрт яг одоо зохион байгуулсан. Уг үйл ажиллагаагаар тус ууланд алхаж, салхилж байгаа иргэдэд эрүүл мэндийн үзлэг зөвлөгөө өгч байна.



- Нийслэлийн түргэн тусламжийн төв нь Япон улсын АМДА Олон улсын байгууллагатай 2013 оноос хамтарч ажиллаж байна. АМДА Олон улсын байгууллагын гүйцэтгэх захирал Тае Намба, тус төвийн захирал Ц.Пүрэвдаш нар 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг харилцан ярилцлаа.



- ХБНГУ-ын Эссэн хотын гал унтраах ангийн парамедикийн сургагч багш Ноён Ёорг Спорс Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн жолооч нарт эмнэлгийн анхан шатны суурь тусламж, шархны цэгцлэлт, автомашины халдвар хамгаалал, 2 хувингийн арга, чих хамар хоолойн яаралтай тусламж, багаар хэрхэн газар дээрх болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламж үзүүлэх сэдэвт 2 өдрийн сургалт амжилттай болж өндөрлөлөө.



- НЭМГ-ийн "Эрдэм шинжилгээний хурал-2019" арга хэмжээнд НТТТ-ийн их эмч З.Баярсайхан түрүүллээ. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран "Эрдэм шинжилгээний хурал-2019" арга хэмжээг өнөөдөр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн хурлын танхимд зохион байгууллаа.



Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг тус арга хэмжээний хүрээнд НЭМГ-аас 2019 оныг "Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэмжих жил" болгосонтой холбогдуулан харьяа эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, судлаач нарын эх, хүүхдийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хэлэлцүүлж, харилцан туршлага солилцон, оношилгоо, эмчилгээний шинэ технологи, бүтээлч санааг нийтэд таниулан, шалгарсан илтгэлийг дэмжин урамшуулж байна.



- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Эссэн хотын орлогч дарга Петр Рензелийг хүлээн авч уулзлаа. Уулзалтад Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар, НЗДТГ-ын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Чинзориг, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш,

Төслийн эмнэлгийн эрүүл ахуйн холбооны дэд ерөнхийлөгч, Хукомед компанийн халдварын хяналт сэргийлэлтийн дарга Волтер Попп, Эссэн хотын Яаралтай түргэн тусламжийн халдварт өвчний тасгийн дарга Иорг Шпросс, Хукомед компанийн микробиологийн лабораторийн эрхлэгч Михайл Россбург болон холбогдох албаныхан оролцов.

Анх 2008 онд “Монгол Улс ХБНГУ хоорондын иж бүрэн түншлэлийн харилцааны хамтарсан тунхаглал”-ыг үндэслэн Эссэн хот болон Улаанбаатар хотуудл харилцан тохиролцон хэлэлцээр хийж байсан. Хоёр хотын хамтын ажиллагаа эрүүл мэндийн салбарт Эмнэлгийн эрүүл ахуй, халдварын сэргийлэлт ба хяналтыг сайжруулах зорилготой “Эмнэлгийн яаралтай түргэн тусламж, эмнэлгийн эрүүл ахуй” /Mongolian Emergency Service Hospital Hygiene Project – MeshHp төсөл нь 2010 оноос эхэлсэн бөгөөд ХБНГУ-аас Монголд эмнэлгийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй олон улсын стандартад нийцэх олон талт үйл ажиллагаанууд хэрэгжин ажиллаж байна. Мөн Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн түргэний жолооч нарт парамедикийн сургалтыг нэвтрүүлсэнээр Нийслэлийн сая гаран хүн амд мэргэшсэн эмнэлгийн жолооч үйлчилж байгаа нь энэ төслийн үр дүн билээ. Уулзалтаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан “Хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн салбарт хийж хэрэгжүүлж буй ажлууд жил ирэх тусам өргөжин тэлж байгаад баяртай байна. Мөн энэ оноос хамтын ажиллагааныхаа хүрээг боловсролын салбараар өргөжүүлэхээр болсонд таатай байна. Цаашдаа бид иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах энэ төслийн үр дүнг илүү амжилттай болгохын тулд хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд бүх талаар нээлттэй байх болно” хэмээлээ.

- Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн 80 жилийн ойг угтсан Нийслэлийн "Хүмүүнлэгийн үйлсийг манлайлагчдыг " алдаршуулах ёслолын арга хэмжээнд Манлайлагч хамт олноор Ц.Пүрэвдаш захиралтай Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн хамт олон шагнагдлаа.



- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын нэрэмжит харьяа байгууллагуудын дунд зохиогдсон спортын 5 төрөлт тэмцээнд Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн баг тамирчид амжилттай оролцож багийн нийлбэр дүнгээр тэргүүн байрын цом, өргөмжлөл гардан авлаа.



- Нийслэлийн хэмжээнд зохиогдож буй Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтийн үеэр Нийслэлийн түргэн тусламжийн төвтэй сүүлийн жилүүдэд хамтран ажиллаж байгаа Япон улсын Окайяма хотод байрладаг ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн гамшгийн үед харилцан туслалцах үйл ажиллагаа явуулдаг “AMDA” ТББ-ийн гүйцэтгэх захирал Намба Сан хүрэлцэн ирж тус төвийн штабын бие бүрэлдэхүүний явуулж буй гамшгийн үеийн үйл ажиллагаатай танилцаж, хэрхэн ажиллах, цаашид анхаарал зүйлсийн талаар зөвөлгөө өгч санал солилцов.



- Улсын хэмжээнд 4 жилд 1 удаа болдог “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-т амжилттай шалгуулж 97 хувь А үнэлгээтэй тэнцлээ. Уг үзлэгийн дагуу байгууллагын хэмжээнд төлөвлөгөө гарган, ажил зохион байгуулж улсын үзлэгт амжилттай шалгууллаа.

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан зохион байгуулсан өрх толгойлсон, олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд тусламж, дэмжлэг үзүүлэх зорилготой “Нэг зүрх-Нэг нийслэл” аяныг бүх шатны төрийн болон төрийн бус байгууллагуудын өрнүүлсэн билээ. Тус сайн үйлсийн аянд Нийслэлийн түргэн тусламжийн төвийн нийт хамт олон амжилттай оролцож "ЦОМ, ӨРГӨМЖЛӨЛ"-р шагнууллаа.



- Нийслэлийн түргэн тусламжийн төвийн чанарын өдөрлөгөөр “Дэлхийн эмч нарын өдөр” угтан байгууллагадаа олон жил тогтвортой сайн ажилласан 47 эмч нараа Төрийн болон салбарын шагналаар урамшуулсан.

Эрүүл мэндийн яамны “ЖУУХ” бичгээр их эмч-1

Нийслэлийн засаг даргын хүндэт жуух бичиг шагналаар их эмч-5



МЗХ-ны тэргүүний залуу алтан медалиар их эмч-4



Сонгинохайрхан, Баянгол дүүргийн засаг даргын ЖУУХ БИЧИГ шагналаар 11 их эмч

- Осол гэмтлээс сэргийлэх жилийг угтаж “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” өдөрлөгийн хүрээнд Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” өдөрлөгийн хүрээнд Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн эмч, жолооч, эмнэлгийн ажилтнууд зохион байгуулалттайгаар амжилттай оролцсон. Өдөрлөгийн үеэр Төв салбар, Хан-Уул салбар, Сонгинохайрхан салбар, Баянзүрх салбар, Авто бааз гэсэн 5 цэгт 80 эмч, сувилагч, жолооч, аж ахуйн албаны хан гэсэн бүрэн бүрэлдэхүүнтэй төв замын дагуу зурагт хуудас, уриа, лоозон, анхааруулга тэмдэг барьж, 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 12:30-13:00 цагийн хооронд олон нийтэд чиглэсэн ажлыг зохион байгуулсан.



#### СУВИЛАХУЙН АЛБАНЫ ОЛОЛТ АМЖИЛТ

- 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Инээмсэглэл эерэг хандлага” “Нийгмийн эрүүл мэндэд сувилагчийн оролцоо” жилийн хүрээнд Нийслэлийн түргэн тусламжийн төвийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нарын дунд ур чадварын тэмцээнийг Төв салбарын хурлын танхимд зохион байгуулсан. Тэмцээнд дөрвөн салбарын нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй 4 баг оролцож ур чадвар авьяас билгээ сорьсон.



- 2019 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нар Чингэлтэй дүүргийн 8-р хорооны засаг дарга Л.Баярсайханы зөвшөөрлөөр хорооны нийгмийн ажилчид, хэсгийн ахлагч нарын тусламжтайгаар “Сувилагчийн нэг өдөр” өдөрлөгийг хорооны иргэний танхимд зохион байгуулсан. Өдөрлөгийн арга хэмжээнд 27 өрхийн 31 иргэн, хорооны ажилтан 11, өөрийн хүсэлтээр 7 иргэн нийт 49 иргэн оролцсон. Нийт 34 иргэнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зөвлөгөө өгсөн.





- 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын сувилагч, тусгай мэргэжилтэн нарын дунд зохион байгуулагдсан “Эрдэм шинжилгээний бага хурал”-д 1 илтгэл шалгарч амжилттай хэлэлцэгдсэн.



- 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байгууллагын нийт ажилтан албан хаагчдын дунд “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ, Инээмсэглэл – эерэг хандлага” сэдэвт эрдмийн чуулганыг сувилахуйн алба, сургалтын алба хамтран амжилттай зохион байгуулсан.

Эрдмийн чуулганд нийт 11 илтгэл ирснээс аман илтгэл-6, ханын илтгэл-5 хэлэлцэгдсэн. Сувилагч тусгай мэргэжилтэн нараас 13 хүн судалгааны ажилд оролцсон.



- 2019 оны 04 дүгээр сард зохион байгуулсан байгууллагын аварга шалгаруулах спортын 4 төрөлтийн тэмцээнд Сувилахуйн алба амжилттай оролцож эмэгтэй сагсан бөмбөг, гар бөмбөгний төрөлд тус бүр алтан медаль, эрэгтэй гар бөмбөгний төрөлд алтан медаль, ширээний теннисийн эмэгтэй төрөлд хүрэл медаль, шатрын төрөлд 5-р байранд орж нэгдсэн дүнгээр дэд байранд орсон амжилт үзүүлсэн.



- 2019 оны

дугаар сард МҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан “Эрүүл агаар-Эв нэгдэл” явган аялалд МЭМАҮЭХ-г төлөөлөн амжилттай оролцож дэд байранд шалгарч мөнгөн медаль өргөмжлөлөөр шагнагдсан.



- 2019 оны 05 дугаар сард Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Үйлдвэрчний Эвлэлийн Хорооны Эмэгтэйчүүдийн хэсгээс зохион байгуулсан “Гар Урлал-Миний Хобби” тэмцээнд 2 сувилагч амжилттай оролцож дэд байр, гуравдугаар байрыг тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.



ХЯНАСАН:  
ЗАХИРАЛ

Ц.ПҮРЭВДАШ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:  
ДЭД ЗАХИРАЛ

С.АРИУНБОЛД

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА

С.АКЕРКЕ

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.ОТГОНТЭНГЭР

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

З.ОРХОНСҮРЭН

ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГА

Д.МӨНХЦЭЦЭГ

СУВИЛАХУЙН АЛБАНЫ ДАРГА

Б.ТАНАЦЭЦЭГ

АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР

С.ОЮУНСУВД

ДҮН БҮРТГЭЛИЙН ЭМЧ

Д.БАЯРСАЙХАН

ХҮҮХДИЙН МЕНЕЖЕР

З.ЭНХЦЭЦЭГ

ЭМИЙН САНГИЙН ЭРХЛЭГЧ

Э.ОЮУНЗУЛ

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

Н.УУГАНЦЭЦЭГ

ПРОГРАМИСТ

С.БЯМБАСҮРЭН

ГАДААД ХАРИЛЦААНЫ АЖИЛТАН

Г.ЭНХЦОГТ

ЗАХИРЛЫН ТУСЛАХ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Д.ЭНХЖАРГАЛ